



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

“Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны  
журам” батлахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.3.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 46.2-д зааснаар кастодианы үйл ажиллагаа эрхлэх журмыг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголбанк хамтран тогтоохоор хуульчилсан тул хавсралтаар танилцуулсан журмын төслийг Монголбанкны Ерөнхийлөгчтэй хамтарсан тушаалаар батлахыг Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд зөвшөөрсүгэй.

2. Үнэт цаасны зах зээлийн харилцаанд үүсэх энэхүү шинэ төрлийн үйлчилгээг хууль, тогтоомж, олон улсын нийтлэг зарчим, үндэсний онцлогт тохирсон хэлбэрээр гүйцэтгэх, дэд бүтцийг бүрдүүлэх, зах зээлийн мэргэжлийн байгууллагууд болон хөрөнгө оруулагчдад хүртээмжтэй хэлбэрээр сурталчлах ажлыг хавсралтаар танилцуулсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

## КАСТОИАНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Санхүүгийн Зохицуулах Хороо /цаашид “Хороо” гэх/-ноос кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сунгах, хүчингүй болгох, уг үйл ажиллагаа эрхлэх нөхцөл шаардлагыг тогтоох болон түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь Иргэний хууль, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай болон холбогдох бусад хууль тогтоомж, Хороо болон бусад эрх бүхий байгууллагаас тогтоосон хэм хэмжээг үйл ажиллагаандаа мөрдөнө.

1.3. Кастодианы үйл ажиллагааг зөвхөн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 46.2-т заасан этгээд эрхэлнэ.

1.4. Хороо болон Монголбанк нь кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Банкны тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, энэ журамд заасан шаардлага хангасан этгээдэд олгоно.

1.5. Хороо болон Монголбанк нь энэ журмаас гадна кастодианы үйл ажиллагаатай холбоотой журам, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад актыг өөрийн бүрэн эрхийн хүрээнд бие даан, эсхүл бусад холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран гаргаж болно.

1.6. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.6.1. “кастодианы үйл ажиллагаа” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 46.1-д заасан үйл ажиллагааг;

1.6.2. “үнэт цаас” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.1-д заасан санхүүгийн хэрэгслийг;

1.6.3. “номиналь эзэмшигч” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.25-д заасан этгээдийг;

1.6.4. “бенефициар өмчлөгч” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.26-д заасан этгээдийг;

1.6.5. “хамтын номиналь данс” гэж нэг буюу түүнээс дээш тооны бенефициар өмчлөгчийг төлөөлөн төвлөрсөн хадгаламжийн байгууллагад тусгайлан нээсэн кастодианы үйл ажиллагаа эрхэлдэг этгээдийн удирддаг дансыг;

1.6.6. “хөрөнгө оруулагч” гэж зохицуулалттай зах зээл болон биржийн бус зах зээлд арилжаалагдаж буй санхүүгийн хэрэгслийг худалдан авсан хувь хүн, хуулийн этгээдийг;

1.6.7. “кастодианы үйл ажиллагаа эрхлэх нэгж” гэж кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээдийн бүтэц дотор уг үйл ажиллагааг дагнан явуулах газар, хэлтэс, тасаг зэргийг;

1.6.8. “компанийн үйл ажиллагаа” (“corporate action”) гэж бүртгэлтэй компанийн эрх бүхий этгээдийн шийдвэрээр компани, түүний энгийн болон давуу эрхтэй хувьцаа эзэмшигч, эсхүл бонд эзэмшигчид нөлөө үзүүлдэг үйл ажиллагаа буюу энэ журмын 3.11-т заасан үйл ажиллагааг;

1.6.9. “ажлын өдөр” гэж Хөдөлмөрийн тухай хуулийн 76.1, 77.1-д заасан өдрөөс бусад өдөр буюу Даваа, Мягмар, Лхагва, Пүрэв, Баасан гарагийг;

### **Хоёр. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох**

2.1. Хороо кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хууль, энэхүү журмын шаардлага хангасан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 46.2-т заасан банк, түүний хараат, эсхүл охин компани, эсхүл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад олгоно.

2.2. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах шаардлагыг хангасан байна:

2.2.1. хууль тогтоомжийн дагуу байгуулагдаж хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн байх;

2.2.2. хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь банк бол Монголбанкнаас тогтоосон, банкнаас бусад этгээд бол Хорооноос тогтоосон шаардлагыг хангасан байх;

2.2.3. энэ журмын 8 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан;

2.2.4. энэ журмын 9 дүгээр зүйлд заасан шаардлага хангасан, банк, санхүү, хөрөнгийн зах зээл дээр ажиллаж байсан туршлага бүхий, үнэт цаасны зах зээл дээр ажиллах эрх авсан, 3-аас дээш жил ажилласан 6 болон түүнээс дээш мэргэжилтэнтэй байх;

2.2.5. эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтэн нь дараах шаардлагыг хангасан байна:

2.2.5.1. ёс зүйн хувьд тухайн тусгай зөвшөөрөл хүсэгчийг удирдахад харшлахгүй байх;

2.2.5.2. төрийн болон эдийн засгийн эсрэг, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй;

2.2.5.3. санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтнаар ажилладаггүй;

2.2.6. Банк бол Банкны тухай хуульд заасан, банкны хараат болон охин компани бол 3-аас доошгүй гишүүнээс бүрдсэн толоолон удирдах зөвлөлтэй байх бөгөөд тэдгээрийн 1-ээс доошгүй нь хараат бус гишүүн байх;

2.2.7. кастодианы үйл ажиллагаа явуулах этгээдэд ажиллах мэргэжилтэн нь үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрхийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан журмын дагуу авсан байх;

2.2.8. кастодианы үндсэн үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэх мэргэжилтнүүд нь энэ журмын 9.9-д заасны дагуу мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдсан байх;

2.2.9. нийтэд холбогдох мэдээлэл хүргэх өөрийн тогтмол ажилладаг цахим хуудастай байх;

2.2.10. энэ журмын 8 дугаар зүйлд заасан Монголбанк, хөрөнгийн бирж, төвлөрсөн хадгаламжийн байгууллага, бусад мэргэжлийн оролцогч болон харилцагчтай мэдээлэл солилцох, төлбөр тооцоо гүйцэтгэх тоног төхөөрөмж, техник, програм хангамжийг бүрдүүлсэн байх;

2.2.11. Монголбанк, хөрөнгийн бирж, төвлөрсөн хадгаламжийн байгууллагын шаардлагын дагуу сүлжээнд холбогдон, мэдээлэл солилцох боломж бүрдүүлсэн байх, бүрдсэн тухай дүгнэлтийг холбогдох байгууллагаас гаргуулсан байх;

2.2.12. энэ журмын 8 дугаар зүйлд заасан шаардлага хангасан, сүлжээ, програм хангамжид гэмтэл, саатал гарсан, давагдангүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тэдгээрт байгаа харилцагчдын мэдээллийн бааз, бусад оюундгийг давхар хадгалах, сэргээх системтэй байх;

2.2.13. хуулиар болон Хорооноос тогтоосон улсын тэмдэгтийн хураамж болон зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тус тус төлсөн;

2.2.14. Хороо, Монголбанкнаас тавьсан бусад шаардлага.

2.3. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь банк бол энэ журмын 2.2-т заасан шаардлагаас гадна дараах нэмэлт шаардлагыг хангасан байна:

2.3.1. кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгаар, бие даасан нэгжтэй байх;

2.3.2. кастодианы үйл ажиллагаа эрхлэх нэгж, түүний эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь хүсэлт гаргагч банкинд бусад албан тушаал, үүргийг давхар гүйцэтгэдэггүй байх;

2.3.3. кастодианы үйл ажиллагаа эрхлэх нэгж нь энэхүү журмын 8 дугаар зүйлд заасан шаардлага хангасан харилцагчид үйлчилгээ үзүүлэх нөхцлийг хангасан дэд бүтэцтэй байх;

2.3.4. кастодианы үйл ажиллагаа эрхлэх нэгжийн бүртгэл, тайлан, тооцоо болон албан бичиг хэрэг хөтлөлт нь банкны үндсэн болон бусад үйл ажиллагааны бүртгэл, тайлан, тооцоо, албан бичиг хэргээс тусдаа хотлогдох нөхцөл боломжоор хангасан, эдгээр мэдээлэлд зөвхөн кастодианы үйл ажиллагаа эрхлэх нэгжид ажиллаж буй ажилтнууд нэвтрэх боломжтой байх;

2.3.5. кастодианы үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийг Хороо болон үнэт цаасны товлорсон хадгаламжийн байгууллагаас санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн гаргасан журмын дагуу явуулж, стандартад шийцсэн нэгжийн хэсэгчилсэн тайлангийн загварыг Хороонд ирүүлсэн байх;

2.3.6. кастодианы үйл ажиллагаа эрхэлж буй нэгжийн мэдээллийн сан болон програм хангамж, төхөөрөмж нь энэ журмын 8 дугаар зүйлд заасан шаардлагыг хангах бөгөөд түүнд хадгалагдаж буй мэдээлэл нь зөвхөн кастодианы үйл ажиллагаа эрхлэх нэгжид ажиллаж буй эрх бүхий ажилтнууд нэвтрэх боломжтой байх;

2.3.7. банкны үйл ажиллагааг 3 жилээс доошгүй хугацаанд эрхэлсэн байх;

2.3.8. хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий бусад албан тушаалтан нь Банкны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар тогтоосон тохиромжтой этгээд байх;

2.4. Кастодианы үйл ажиллагаа эрхлэхээр хуульд заасан тусгай зөвшөөрөл хүсэгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 27.2, Банкны тухай хуулийн 6.3-д зааснаас гадна дор дурдсан баримт бичиг, холбогдох материалыг Хороонд ирүүлнэ:

2.4.1. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

2.4.2. нэгдмэл сонирхолтой этгээд /холбогдох этгээд/-ийн талаарх мэдээлэл, танилцуулга;

2.4.3. төлөөлөн удирдах зөвлөл, аудитын хорооны дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлагын талаарх дор дурдсан мэдээлэл:

2.4.3.1. Дэлгэрэнгүй анкет;

2.4.3.2. банк болон банк бус санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн зээлтэй, хугацаандаа татвар төлөөгүй, эсхүл хугацаа хэтрүүлж төлсөн өр, төлбөртэй, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу өр төлбөртэй эсэх тухай тодорхойлолт.

2.4.3.3. Хороо энэхүү журмын 2.4.3.2-т заасан банк, банк бус санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн зээлтэй эсэх тодорхойлолтыг хууль тогтоомжид нийцүүлэн цагдаагийн байгууллага, эсхүл Зээлийн мэдээллийн санд хандан авна.

- 2.4.4. кастодианы үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой дор дурдсан дотоод дүрэм, журмууд:
- 2.4.4.1. харилцагчийн мэдээлэл, баримт бичгийг ашиглах, хадгалах, хамгаалах журам;
  - 2.4.4.2. кастодианы үйлчилгээтэй холбоотой мэдээллийг харилцагчид хүргэх журам;
  - 2.4.4.3. гүйцэтгэх удирдлага болон ажилтнуудын ёс зүйн дүрэм;
  - 2.4.4.4. сонирхлын зөрчлийг тодорхойлох, сэргийлэх, илрүүлэх, мэдээлэх журам;
  - 2.4.4.5. давагдашгүй хүчин зүйл болон хүний үйл ажиллагаанаас шалтгаалсан гамшиг зэрэг гадны хүчин зүйл үүсэхэд сэргийлэх, авах арга хэмжээний тухай журам;
  - 2.4.4.6. зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх журам;
  - 2.4.4.7. эдийн засгийн болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам;
  - 2.4.4.8. кастодианы үйл ажиллагаа явуулах ажлын байр нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өөрийн байр бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, хэрэв түрээсийн байр бол түрээсийн гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- 2.4.5. тусгай зөвшөөрөл хүсэгчийн Хороонд бүртгэлтэй аудитын компаниар, эсхүл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын компаниар баталгаажуулсан сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан;
- 2.4.6. энэ журмын 10 дугаар зүйлд заасан шаардлага хангасан эрсдэлийн удирдлагын бодлого;
- 2.4.7. техник, програм хангамжийн талаарх техникийн тодорхойлолтыг энэ журмын 8 дугаар зүйлд заасан шаардлага хангасан эсэхийг тодорхойлох;
- 2.4.8. кастодианы үйл ажиллагаа эрхлэх нэгжийн эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтний хавсралтаар баталсан дэглэрэнгүй авкет;
- 2.4.9. Банкны тухай хуулийн 6.4-д зааснаар кастодианы үйл ажиллагаа эрхлэхэд тагналзахгүй тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн албан бичиг;
- 2.4.10. Хорооноос үндэслэлтэй гэж үзсэн бусад баримт бичиг.

2.5. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хугацаагүйгээр олгох боловч Хороо хууль тогтоомж, энэ журмын 13 дугаар зүйлд заасны дагуу түдгэлзүүлэх, хүчингүй болгож болно.

2.6. Хороо кастодианы үйл ажиллагаа эрхлэхээр тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн өргөдөл, холбогдох баримт бичгүүдийг бүрэн гүйцэд хүлээн авснаас хойш хуанлийн 30 хоногт хянаж шийдвэрлэнэ.

2.7. Хороо баримт бичгийг магадлан шинжлэх, нэмж тодруулах зорилгоор кастодианы үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл хүсэгчээс нэмэлт баримт бичиг шаардсан бол нэмэлт баримт бичгийг ирүүлсэн өдрөөс хуанлийн 20 хоногт хянаж шийдвэрлэнэ.

2.8. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгчээс ирүүлсэн баримт бичгийг дараах тохиолдолд хуанлийн 20 хоногийн дотор тусгай зөвшөөрөл хүсэгчид буцаана:

2.8.1. тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж болон энэхүү журамд заасан шаардлагыг хангаагүй;

2.8.2. тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлт нь энэхүү журмын 2.2 болон 2.3-т заасан тусгай зөвшөөрлийн холбогдох нөхцөл, шаардлагыг хангаагүй;

2.8.3. тусгай зөвшөөрөл хүсэгч нь хуурамч бичиг баримт ирүүлсэн буюу ашигласан нь тогтоогдсон;

2.8.4. энэхүү журмын 2.8.3. дахь хэсэгт заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон буюу зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд дахин зөвшөөрөл хүсэх тухай бичиг баримтыг 1 жилийн дотор Хороонд ирүүлсэн;

2.8.5. хууль тогтоомжид заасан болон Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад тохиолдол.

2.9. Энэ журмын 2.8-д заасны дагуу тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичгийг буцаахдаа тодорхой үндэслэл бүхий тайлбарын хамт тусгай зөвшөөрөл хүсэгчид бичгээр хүргүүлнэ.

2.10. Хороо бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн гэх үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд энэ тухай тусгай зөвшөөрөл хүсэгчид мэдэгдсэнээс хойш нэг жилийн хугацаанд уг этгээдийн хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зовлолийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлагатай нэгдмэл сонирхолтой хуулийн этгээдээс (холбогдох этгээдээс) тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг дахин хүлээж авахгүй.

2.11. Хороо тусгай зөвшөөрөл хүсэгчид кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон тохиолдолд зохих журмын дагуу тусгай зөвшөөрлийн нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

### **Гурав. Кастодианы үйл ажиллагаа, түүний төрөл**

3.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 46.1-д зааснаар үнэт цаас өмчлөгчийн өмчлөл дэх үнэт цаасыг хадгалах, үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх бусад эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйлчилгээг үзүүлэх ажиллагааг кастодианы үйл ажиллагаа гэнэ.

3.2. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 51.1.3-51.1.5-т зааснаар үнэт цаасны тухайлсан бүртгэл, түүнтэй холбоотой тооцоо, үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагаа болон Хорооноос тухай бүр зөвшөөрсөн бусад торлийн зохицуулалттай үйл ажиллагааг хавсран эрхэлж болно.

3.3. Хороо кастодианы үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч этгээдэд үнэт цаасны тухайлсан бүртгэл болон үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хамт олгож болно.

3.4. Энэ журмын 3.1-д заасан кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь дараах үйл ажиллагааг явуулна:

3.4.1. биет боловч биет бус үнэт цаас, харилцагчийн мөнгөн хөрөнгө болон төлбөрийг үл буцаахаар гүйцэтгэх;

3.4.2 үнэт цаасны бенефициар өмчлөгч, эсхүл түүний төлөөлөгчтэй энэ журмын 5 дугаар зүйлд заасан кастодиан үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулах;

3.4.3. өөрийн мөнгөн хөрөнгө, үнэт цаасыг харилцагчийнхаа мөнгөн хөрөнгө, үнэт цааснаас ямагт тусгаарлан хадгалах;

3.4.4. харилцагчийн мөнгөн хөрөнгө, үнэт цаасыг бусад харилцагчийн мөнгөн хөрөнгө, үнэт цааснаас ямагт тусгаарлан хадгалах;

3.4.5. биет үнэт цаасыг хадгалахад түүний бүрэн бүтэн байдлыг хангаж үнэт цаас тус бүрийн эзэмшигч, ангилал, торлийг тодорхой зааж, хадгалалтын нууцлал, найдвартай, аюулгүй байдлыг хангах;

3.4.6. биет бус үнэт цаасыг хадгалахад үнэт цаас тус бүрийн эзэмшигч, ангилал, төрлийг цахим бүртгэлд тодорхой бүртгэн харилцагч тус бүрийн мөнгөн хөрөнгө болон үнэт цаасыг тусад нь бүртгэх;

3.4.7. хадгалагдаж байгаа үнэт цаасны талаарх дараах мэдээлэл бүхий санг бүрдүүлж хотлох:

3.4.7.1. үнэт цаасны саналын эрх, хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдах огноо;

3.4.7.2. үнэт цаасны гүйлгээг тусгаарласан эсэх, үнэт цаасыг бусдад шилжүүлэхэд тавьсан бусад хязгаарлалт;

3.4.7.3. үнэт цаасанд ногдох татвар, түүний төлөлттэй холбоотой мэдээлэл;

3.4.7.4. кастодианы үйл ажиллагааг явуулахад шаардлагатай, энэ журмын 3.32.1-3.32.8-д заасан мэдээлэл.

3.5. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь компанийн үйл ажиллагаанд харилцагчийн нэрийн өмнөөс цаг тухайд нь оролцох ба үүнийг дараах хэлбэрээр гүйцэтгэнэ:

3.5.1. эзэмшлийн хувьцаатай нь холбоотойгоор энэ журмын 3.11-т заасан компанийн үйл ажиллагаанд харилцагчтай байгуулсан гэрээний дагуу түүнийг төлөөлөн оролцох;

3.5.2. компанийн үйл ажиллагааны талаарх холбогдох мэдээллийг авч харилцагчид бичгээр мэдээлэл хүргүүлж, түүний нэрийн өмнөөс ирүүлсэн зааварчилгааг хэрэгжүүлэх;

3.5.3. бенефициар өмчлөгч, эсхүл түүний төлөөлөгчийн бичгээр өгсөн заавар байхгүй бол кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь Компаний тухай хуулийн хувьцаа эзэмшигчдийн эрх болон кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээгээр олгогдсон эрхийг хэрэгжүүлэх;

3.5.4. харилцагчтай байгуулсан кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан бол харилцагчид ногдох татварын хэмжээг хууль журмын дагуу тооцоолон, түүнд мэдэрлэх, харилцагчийн нэрийн өмнөөс гэрээний дагуу зохих байгууллагад төлбөл зохих татварыг шилжүүлэх, түр хойшлуулах, илүү төлөгдсөн татварыг эргүүлэн нэхэмжлэх;

3.5.5. компанийн аливаа үйл ажиллагаанд кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь харилцагчийн ашиг сонирхлыг төлөөлөн оролцох бөгөөд кастодиан болон харилцагчийн мөнгөн хоронго, үнэт цаасны дансыг ямагт тусад нь байлгах.

3.5.6. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь Компанийн тухай хуулийн 64.1-д заасны дагуу үнэт цаас гаргагч, эсхүл төвлөрсөн хадгаламжийн байгууллагын хүсэлтээр хувьцаа эзэмшигчид /бенефициар өмчлөгчид/-ийн нэрс, тус бүрийн хувьцааны шилжилт хөдөлгөөнийг тусгасан тархалтын дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж өгнө.

3.5.7. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь харилцагч тус бүрээс хувьцаа эзэмшигчдийн хуралд ямар хэлбэрээр оролцож санал өгөх эрхээ хэрэгжүүлэхийг бичгээр асуух, хариулыг бичгээр авах, ба хувьцаа эзэмшигчдийн хурлын тов, хэлэлцэх асуудал, хурлаас гарсан мэдээллийн торол болон харилцагчийг төлөөлж санал огох тухай түүнээс ирүүлсэн зааварчилгаа зэргийг дэлгэрэнгүй мэдээллийн хамт хадгална.

3.6. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь харилцагчийн төлбөр гүйцэтгэх зорилгоор нэг болон түүнээс дээш мөнгөн хөрөнгийн данс нээж болно. Ийм данс нь дараах нөхцлийг хангасан байна:

3.6.1. дансны төрөл, нөхцөл, шимтгэлийг кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээнд нарийвчлан заасан байх;

3.6.2. цахим бүртгэл дэх харилцагчдын мөнгөн хөрөнгийг харилцагч тус бүрээр нь болон өөрийн (кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдийн) мөнгөн хоронгоноос ямагт тусгаарлан бүртгэнэ;

3.6.3. харилцагчийн данс дахь мөнгөн хөрөнгийг өөрийн хэрэгцээнд ашиглахыг хориглоно;

3.6.4. харилцагчийн данс тус бүрийн мөнгөн хөрөнгөд тулгалт хийж, түүний бүрэн бүтэн байдлыг хангах бөгөөд хамгийн сүүлд хийгдсэн гүйлгээний талаарх мэдээллийг кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан давтамжтайгаар харилцагчид хүргүүлэх.

3.7. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь харилцагчаас барьцаа шаардаж болох бөгөөд тухайн барьцааны зүйлийг зөвхөн харилцагч, эсхүл түүний төлөөлөгчийн төлбөр төлөх үүргээ биелүүлдэггүй нөхцөлд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу захиран зарцуулж болно.

3.8. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь харилцагчийн эзэмшиж буй санхүүгийн хэрэгсэл, түүнийг гаргагчийн тухай болон бусад мэдээллийг кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасны дагуу харилцагчид гаргаж өгнө.

3.9. Бүртгэлтэй компанийн ТУЗ-ын шийдвэрээр компанид болон энгийн болон давуу эрхтэй хувьцаа эзэмшигчид, бонд эзэмшигчдэд бодит өөрчлөлт бүхий нөлөө үзүүлдэг үйл явдлын компанийн үйл ажиллагаа (corporate action) гэнэ.

3.10. Компанийн үйл ажиллагааг уг журмын 3.11.1-3.11.13-д дурдсан төрлөөр хязгаарлахгүй.

3.11. Кастодиан нь дор дурдсан үйл ажиллагаатай холбоотой кастодианы үйлчилгээг харилцагчид заавал үзүүлэх бөгөөд энэ журмын нэгдүгээр хавсралтаар баталсан жагсаалтад дурдсан компанийн үйл ажиллагааг харилцагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгэж болно:

3.11.1. хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурал (Annual General Meeting of Shareholders, Extraordinary General Meeting of Shareholders);

3.11.2. компанийн хувьцааг худалдан авах замаар охин, хараат компани болгох (Acquisition);

3.11.3. нэмж хувьцаа гаргах (Capital Increase);

3.11.4. үнэт цаасыг хөрвүүлэх (Conversion of Equities and Debt Instruments);

3.11.5. бондын хүүгийн хуваарьт төлбөр (Coupon Payment of Debt Instruments);

3.11.6. компанийг нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах (De-merger/Spin-Off, Merger);

3.11.7. ногдол ашиг (Dividend);

3.11.8. үнэт цаасыг оор торлийн үнэг цаасаар солих, эсхүл монгоор арилжих (Exchange);

3.11.9. татан буулгах (Liquidation);

3.11.10. итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан санал өгөх (Proxy voting);

3.11.11. бондын цэрлэсэн үнийн эргэн төлөлт (Redemption of Debt Instruments);

3.11.12. хувьцааг хуваах, нэгтгэх (Reverse Split);

3.11.13. илүү төлсөн татварын буцаалт (Tax Reclamation in case of Equities and Debt Instruments).

3.12. Кастодиан нь энэ журмын 3.11.1-3.11.13-д заасан компанийн үйл ажиллагааг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

3.12.1. журмын 3.11.1-д заасан компанийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох урилгыг төвлөрсөн төв хадгаламжийн байгууллагаас



харилцагчийн өмнөөс хүлээн авч, хурлын зарыг хэлэлцэх асуудлын жагсаалтын хамт харилцагчид хүргүүлж, кастодианаар төлөөлүүлэн хуралд оролцож, санал өгөх хүсэлтэй байгаа эсэхийг нь асуух үүрэгтэй. Хэрэв харилцагч хуралд оролцож санал өгөх хүсэлтэй байгаа бол холбогдох итгэмжлэлийг (ргоху) хурлаас гарах асуудал тус бүрээр хэрхэн санал өгөх зааврыг харилцагчаас авна;

3.12.2. журмын 3.11.2-т заасан компанийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд худалдаж авсан охин, эсхүл хараат компанийн хувьцааг харилцагчийн нэрийн өмнөөс эзэмшиж байвал эдгээр хувьцааг шинээр бүртгэж, харилцагчийн дансан дахь хөрөнгийн бүртгэлд холбогдох өөрчлөлтийг тусгана;

3.12.3. журмын 3.11.3-т заасан компанийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нэмж гаргах хувьцаанаас худалдан авахаар захиалга өгөх эрхтэй талаар харилцагчид мэдэгдэж, хувьцаа авах захиалга өгөх эсэхийг тодорхойлно. Хэрэв харилцагч захиалга өгч хувьцаа нэмж худалдан авах эрхээ хэрэгжүүлэхийг хүсвэл кастодиан нь хувьцаа эзэмшигчийн нэрийн өмнөөс уг ажлыг гүйцэтгэнэ.

3.12.4. журмын 3.11.4-т заасан компанийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд кастодиан нь харилцагчид үнэт цаасны хөрвөх нөхцлийн талаар мэдээлж, харилцагчийг үнэт цаасаа хөрвүүлэх хүсэлтэй байгаа эсэхийг нь лавлана. Харилцагчийн хүсэлтийг үндэслэн хөрвүүлэх үнэт цаасыг ташилцуулж, хөрвөсөн үнэт цаасыг харилцагчийн нэрийн өмнөөс хүлээж авч бүртгэнэ.

3.12.5. журмын 3.11.5-д заасан компанийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд кастодиан нь бондын хүүгийн төлбөр төлөх өдрөөс өмнө харилцагч хүүгийн төлбөр авах эрх үүссэн эсэхийг шалгаж, хэрэв ийм эрх үүссэн бол харилцагчийн нэрийн өмнөөс хүүгийн төлбөрийг хүлээж авч, харилцагчийн дансанд шилжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.12.6. журмын 3.11.6-д заасан үйл ажиллагаатай холбогдолтой шаардлагатай бүхий л мэдээллийг урьдчилан авч, компанийн нэгдэх, шийлэх, хуваах, тусгаарлах нөхцлөөс хамааран харилцагчийг уг ажиллагаанд санал өгөх байдлаар оролцох хүсэлтэй байгаа эсэхийг тодруулна. Харилцагчийг төлөөлж шаардлагатай ажиллагааг гүйцэтгэх ба компанийг тусгаарлах, хуваах үйл ажиллагааны үр дүнд харилцагчид ногдох хувьцааг түүний дансанд байршуулна.

3.12.7. журмын 3.11.7-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ногдол ашиг төлөх өдрөөс өмнө харилцагч ногдол ашгийн төлбөр авах эрх үүссэн эсэхийг шалгана. Кастодиан нь зохих мөнгөн дүнг харилцагчийн нэрийн өмнөөс хүлээж авч, харилцагчийн дансанд шилжүүлэх ажлыг зохион байгуулж, шилжүүлсэн төлбөрөөс эх сурвалж дээр нь тооцож хассан аливаа суутгалын (жишээ нь, суутгах татвар, шимтгэлийг) үнэн зөв эсэхийг хянана. (“Илүү төлсөн татварын буцаалт” гэсэн 3.12.13 дахь хэсгийг үзнэ үү);

3.12.8. журмын 3.11.8-д заасан компанийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд харилцагчид хариу өгөх хугацааг олгох үүднээс кастодиан нь үнэт цаас оор төрлийн үнэт цаасаар солилцох, эсвэл мөнгөн хөрөнгөөр арилжих саналыг урьдчилан хүлээж авна. Кастодиан нь мэдээллийг хүлээж авсан даруйд харилцагчид мэдэгдэж, солилцоо, арилжааг хийх саналыг хүлээж авах эсэхийг түүнээс лавлана. Саналыг хүлээж авбал кастодиан солилцоо, арилжааг гүйцэтгэж, үнэт цаас, эсхүл мөнгөн хөрөнгийг харилцагчийн дансанд шилжүүлнэ;

3.12.9. журмын 3.11.9-т заасан компанийн үйл ажиллагаатай холбогдох мэдээллийг нэн даруй хүлээн авсан байх шаардлагатай. Үүний дараа харилцагчид мэдэгдэж, татан буулгах ажиллагааг гүйцэтгэх эрх бүхий этгээдээс (хэрэг гүйцэтгэгч, татан буулгах комисс) харилцагчийн эзэмшиж буй хувьцааны үнийн дүнг буцаан авах арга хэмжээ авна. Кастодиан нь татан буулгах эрх бүхий этгээдээс хүлээж авсан мөнгөн хөрөнгийг харилцагчийн дансанд байршуулна.

3.12.10. журмын 3.11.10-г заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон кастодиан хувьцаа эзэмшигчдийн хуралд харилцагчийн нэрийн өмнөөс оролцож, санал өгөх ба ингэхдээ харилцагчийн бичгээр ирүүлсэн зааврыг дагана;

3.12.11. журмын 3.11.11-г заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд кастодиан нь харилцагчийн эзэмшиж буй бондын хугацаа дуусгавар болж байгаа эсэхэд ханалт тавих шаардлагатай. Бондын хугацаа дуусахад кастодиан энэ тухай бонд гаргагчид мэдэгдэж, бондын нэрлэсэн үнийн төлбөрийг хүлээн авч, мөнгөн хөрөнгийг харилцагчийн дансанд шилжүүлнэ.

3.12.12. журмын 3.11.12-г заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд кастодиан нь хувьцааг хуваах, нэгтгэх тухай мэдээллийг урьдчилан хүлээн авч, харилцагчид мэдэгдэнэ. Хувьцааг хувааж эсвэл нэгтгэсний дараа кастодиан хувьцааны шинэ ханшийг үндэслэн харилцагчийн эзэмшлийн хувьцааг шинээр бүртгэж, хувьцааны шинэ ханш, позицгийн талаар харилцагчид мэдэгдэнэ.

3.12.13. журмын 3.11.13-д заасан тохиолдолд нэн түрүүнд давхар татварын гэрээ нь харилцагчид хамаарах эсэхийг тодорхойлно. Хэрэв харилцагч нь илүү төлсөн татварын дүнг нөхөн төлүүлэх бол үүнийг тооцоог кастодиан хийнэ. Мөн энэхүү эргэн төлөлтийн мөнгийг олж авах явцыг олж мэднэ. Энэ үйл явцыг олж мэдснээр кастодиан нь харилцагчийн өөрийн өмнөөс татварын нөхөн төлбөрийг нэхэмжилнэ. Нэхэмжилсэн нөхөн төлбөрийг хүлээж авмагц харилцагчийн дансанд шилжүүлнэ.

3.13. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь харилцагч, эсхүл түүний төлөөлөгчийн бичгээр зөвшөөрөл олгосноос бусад тохиолдолд түүний мөнгөн хөрөнгө, үнэт цаасыг захиран зарцуулахыг хориглоно.

3.14. Үнэт цаасны тухайлсан бүртгэлд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан үйл ажиллагааг ойлгоно.

3.15. Үнэт цаасны тухайлсан бүртгэлийг хавсран эрхлэх кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь дараах үүргийг гүйцэтгэнэ:

3.15.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 42.4-г заасны дагуу үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад заавал гишүүнчлэлтэй байх ба хадгаламжийн байгууллагад данстай байх;

3.15.2. бенефициар өмчлөгч, түүний төлөөлөгч, түүнчлэн хамтын номиналь дансны номиналь эзэмшигч болон Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг бүртгэж, тогтмол шинэчилж байх;

3.15.3. энэ журмын 3.32-д заасан мэдээллийг өөрийн мэдээллийн баазад хадгална;

3.16. Үнэт цаасны тухайлсан болон төвлөрсөн бүртгэлийн мэдээлэл нь тохирч байх ба кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь тухайлсан бүртгэлийн үнэн зөв байдлыг баталгаажуулан үнэт цаасны төвлөрсөн хадгаламж дахь төвлөрсөн бүртгэлтэй тулгалт хийнэ.

3.17. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь үнэт цаасны өмчлөх эрхийг шилжүүлэхтэй холбоотой мэдээллийг бүртгэлд тусгаж, тогтоосон хугацааны турш хадгалж, Хороо болон Монголбанкнд холбогдох тайлан мэдээллийг хүргүүлнэ.

3.18. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлд үнэн зөв, бүрэн бүтэн мэдээллийг оруулах үүрэгтэй ба алдаатай мэдээлэл оруулсны улмаас учирсан хохирлыг буруутай этгээд хариуцна.

3.19. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь бенефициар өмчлөгчийн үнэт цаас болон түүний өмчлөх эрхэд өөрчлөлт гарах бүрт холбогдох өөрчлөлтийг хийж, өмчлөх эрхийн бүртгэлийг шинэчилж байна. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 44.2-т заасан үнэт цаасны тухайлсан бүртгэлийн өөрчлөлт нь үнэт цаасны төвлөрсөн бүртгэлд нэгдсэн байдлаар тухай бүр бүртгэгдэнэ.

3.20. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 51.1.4-т заасан үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагааг хавсран эрхэлж болно.

3.21. Үнэт цаасны арилжааны төлбөрийн үйл ажиллагаанд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 44.1-д заасан үйл ажиллагааг ойлгоно.

3.22. Үнэт цаасны арилжааны төлбөрийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 44.2-т заасан хугацаанд гүйцэтгэх бөгөөд уг үйл ажиллагааг гүйцэтгэхдээ кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдийн өөрийн болон харилцагчийн арилжааг мөнгөн хөрөнгийн данс болон хувьцааны дансыг ашиглаж гүйцэтгэнэ.

3.23. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь энэ журмын 3.8-д заасан оорийн мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны дансыг харилцагчийн данснаас ямагт тусад нь хадгална.

3.24. Үнэт цаасны арилжааны төлбөрийн үйл ажиллагаанд гүйлгээг гүйцэтгэж, төлбөрийг шилжүүлсэн баримт бүхий санхүүгийн бүртгэл хөтөлж, мэдээллийн санд оруулж, хадгалах, энэ мэдээллийг бенефициар өмчлөгч болон түүний төлөөлөгчид (номиналь эзэмшигч) тооцооны баримт, тайлан хэлбэрээр мэдээлнэ.

3.25. Үнэт цаасны арилжааны төлбөрийг “Delivery versus Payment” буюу төлбөр бүрэн хийгдсэн тохиолдолд үнэт цаасны өмчлөх эрхийг шилжүүлэх зарчмыг баримтлан гүйцэтгэнэ.

3.26. Төлбөрийн үйл ажиллагаа нь үнэт цаасны худалдагч төлбөрийн мөнгийг, харилцагч үнэт цаасыг кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдийн тус тусын дансанд байршуулснаар дуусах бөгөөд ингэснээр үнэт цаасны өмчлөх эрх нь бенефициар өмчлөгч, эсхүл түүний төлөөлөгч (номиналь эзэмшигч)-д шилжсэнд тооцно.

3.27. Хороо, Монголбанк, Монголын хөрөнгийн бирж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн тов тус тусын чиг үүргийн хүрээнд үнэт цаасны арилжааны төлбөрийн нарийвчилсан журам, заавар, аргачлалыг дангаараа, эсхүл хамтран гаргаж болно.

3.28. Үнэт цаасны төвлөрсөн бүртгэлийн үйл ажиллагааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 45.2-т зааснаар зөвхөн үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд гүйцэтгэнэ.

3.29. Үнэт цаасны төвлөрсөн бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь Үнэт цаасны зах зээлийн тухай, Компанийн тухай хуульд зааснаас гадна дараах үүргийг гүйцэтгэнэ:

3.29.1. Нийтэд санал болгон гаргасан үнэт цаасыг үнэт цаасны төвлөрсөн бүртгэлд бүртгэх;

3.29.2. гаргасан хувьцаа бүрт төвлөрсөн хадгаламжийн товд байгаа дансуудын хооронд гарсан оорчлолтийг бүртгэж, үнэт цаасны тухайлсан бүртгэлд байгаа мэдээлэлтэй өдөр бүр тулгалт хийж, номиналь эзэмшигч бүрээр гаргах;

3.29.3. төвлөрсөн хадгаламжийн төв нь нийт зарласан болон гаргасан хувьцааны тоо ширхэг, Монголын хөрөнгийн бирж дээр нийтлэгдсэн хувьцааны хамгийн сүүлийн үеийн үнэ, хувьцаа гаргагчийн тухай болон бусад холбогдох мэдээлэл бүхий бүртгэлийг хөтлөх.

3.30. хуулийн этгээдийн үнэт цаасны бүртгэл нь нэгдсэн тогтолцоотой байх ба хуулийн этгээд бүрийн бүртгэлийг бусад хуулийн этгээдийн бүртгэлээс тусад нь хөтөлнө. Бүртгэлд хувьцаа эзэмшигч тус бүрийг бүртгэлд нэг удаа тэмдэглэж, түүний эзэмшлийн хувьцааг нэгдсэн дүнгээр илэрхийлнэ. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нь үнэт цаас бүрт үнэт цаасны олон улсын нэгдсэн дугаарыг үнэт цаасны олон улсын нэгдсэн кодын стандартын дагуу олгоно.

3.31. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид номиналь эзэмшигч /кастодиан/-ийн дансны мэдээлэл байх ба төвлөрсөн хадгаламжийн байгууллага үнэт цаас гаргагчийн хүсэлт, эсхүл Компанийн тухай хуульд заасан тохиолдолд бенефициар өмчлөгчийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг номиналь эзэмшигчээс шаардах эрхтэй.

3.32. Үнэт цаасны төвлөрсөн бүртгэлд дараах мэдээлэл хадгалагдахаа:

3.32.1. санхүүгийн хэрэгслийн төрөл (ISO 10962 стандартын дагуу);

3.32.2. үнэт цаас гаргагчийн нэр;

3.32.3. үнэт цаасны олон улсын нэгдсэн код, таних код;

3.32.4. нэрлэсэн үнэ, нэрлэсэн үнийг илэрхийлсэн валют;

3.32.5. бүртгүүлсэн газар;

3.32.6. бондын хувьд нэрлэсэн үнэ, илэрхийлсэн валют, гаргасан өдөр, гаргасан газар, дуусах хугацаа, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа,

3.32.7. хувьцааны хувьд хувьцаа эзэмшигчдийн хурлын огноо, хувьцааг бусдад шилжүүлэхэд тавьсан хязгаарлалт, татвар, тусгай нөхцөл,

3.32.8. төвлөрсөн хадгаламжийн байгууллагаас шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

### **Дөрөв. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдийн нийтлэг үүрэг**

4.1. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь үйл ажиллагаандаа дараах нийтлэг үүргийг баримталж ажиллана:

4.1.1. харилцагчийн талаар хангалттай мэдээллийг агуулсан холбогдох баримт бичгийг үндэслэн кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээг харилцагч тус бүртэй байгуулах;

4.1.2. харилцагчтай кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулахдаа түүний шаардсанаар өөрийн дотоод дүрэм, журам, санхүүгийн тайлан болон холбогдох хууль тогтоомжид заасан мэдээлэл, баримт бичгийг танилцуулах;

4.1.3. кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу харилцагчийн дансан дахь монгол хөрөнгийг ялгал тодорхойлж, өөрийн хөрөнгөөс тусгаарлан найдвартай хадгалах;

4.1.4. харилцагчийн дансанд хийгдсэн аливаа гүйлгээ, шилжүүлгийн талаар дараа өдөрт багтаан гэрээнд заасан хэлбэрээр харилцагчид мэдэгдэх;

4.1.5. харилцагчийн дансанд хийгдсэн гүйлгээ болон үнэт цаас, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл бүхий дансны дэлгэрэнгүй хуулгыг сар тутам цахим хэлбэрээр буюу харилцагчийн шаардсан бусад арга, хэлбэрээр хүргэх;

4.1.6. харилцагчийн идэвхтэй байгаа болон хаагдсан данс, түүнд хийгдсэн гүйлгээтэй холбоотой мэдээлэл, баримт бичгийг 10-аас доошгүй жил хадгалах, цаашид харьяалагдах хадгаламжийн байгууллагад хүргүүлэх;

4.1.7. харилцагчид тогтмол хүргэхээр заасан түүний дансны талаарх мэдээ, тайлан, хуулгыг гэрээнд заасан хэлбэрээр хүргүүлэх, эсхүл хэвлэж өгөх;

4.1.8. кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдийн дотоод бүртгэлийн системд байгаа харилцагчийн данстай холбоотой мэдээллийн нууцлалыг хангаж ажиллах;

4.1.9. үнэт цаас гаргагч, түүний төлөөлөгч болон төвлөрсөн хадгаламжийн байгууллагаас харилцагчид мэдээлэх болон хүргэхээр ирүүлсэн мэдээлэл, тайланг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор харилцагчид мэдээлэх;

4.1.10. кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь харилцагчийн дансан дахь хөрөнгийг зөвхөн харилцагч, эсхүл түүний төлөөлөгчийн зөвшөөрөл буюу даалгавар болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тусгаарлах буюу шилжүүлэх;

4.1.11. кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан бусад үүрэг.

4.2. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь харилцагчийн хөрөнгийн хадгалалт болон холбогдох бүртгэлийг гүйцэтгэхдээ дор дурдсан үүргийг гүйцэтгэнэ:

4.2.1. харилцагчийн үнэт цаасны бүртгэл хөтөлж, тухайн үнэт цаастай холбоотой гүйлгээ хийхэд үнэт цаасыг аяхны шаардлагаар бэлэн байлгах;

4.2.2. харилцагчийн үнэт цаас, мөнгөн хөрөнгөтэй холбоотой гүйлгээг зохих журмын дагуу хийж гүйцэтгэх;

4.2.3. үнэт цаасаар гэрчлэх эрхийг төвлөрсөн хадгаламжийн байгууллагаар баталгаажуулж харилцагчид хүргэх;

4.2.4. Монгол Улсын хууль тогтоомж болон кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан бусад үүрэг.

4.3. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь дотоод хяналтын нэгжийг заавал ажиллуулах ба тус нэгж нь энэ журмын 4.1 болон 4.2-т заасан үйл ажиллагаанд хяналт тавина.

4.4. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь энэ журмын 4.1, 4.2-т заасан үйлчилгээг үзүүлэхдээ дараах чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй:

4.4.1. кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдийн харилцагчийн дансан дахь хөрөнгийн байршил, хөдөлгөөнийг бүртгэх, хадгалах, хамгаалах нөхцөл, дэд бүтцийг бүрдүүлэн ажиллах;

4.4.2. өөрийн хөрөнгө ба харилцагч бүрийн хөрөнгийг тус тусад нь бүртгэж, хадгалах;

4.4.3. үнэт цаас, түүнийг худалдсан, эсхүл худалдан авсны орлого, компанийн үйл ажиллагааны орлого, хүүгийн төлбөрийг хүлээн авч харилцагчийн дансанд байршуулах;

4.4.4. энэ журам, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үнэт цаас, бусад хөрөнгийн бүртгэл, дансыг хөтлөх;

4.4.5. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 22, 23 дугаар зүйл, Компанийн тухай хуулийн 57 дугаар зүйлд заасан үүргийг хэрэгжүүлэх хүрээнд бүртгэлтэй хувьцаат компанийн хувьцааг ганцаараа болон хамтран эзэмшиж буй бенефициар омчлөгчийн өмчлөлийн хэлбэрийг хянаж, тулгалт хийх, энэ талаар холбогдох этгээдэд мэдээлэх;

4.4.6. Хорооноос шаардсан бол кастодианаас эзэмшлийн талаарх хувийн болон санхүүгийн мэдээлэл зэрэг хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй мэдээллийг 3 өдрийн дотор гаргаж өгөх;

4.4.7. Хорооноос хяналт шалгалт хийх явцад кастодианы үйл ажиллагаа болон харилцагчийн өмчлөлийн талаарх бүртгэл, тайлан, мэдээллийг хянах, шалгах нөхцлийг бүрдүүлэх;

4.4.8. энэ журмын 10 дугаар зүйлээр тогтоосон нөөц хөрөнгө болон заавал байлгах хөрөнгийн зохистой харьцаа, харилцагчдыг эрсдэлээс хамгаалах талаарх шалгуурыг хангаж ажиллах;

4.4.9. өөрийн гүйцэтгэх захирал, эсхүл санхүү хариуцсан захирлын баталгаажуулсан логжийн хэсэгчилсэн санхүүгийн тайланг улирал тутам гаргаж, тайланг үеийн дараа сарын 20-ны өдрийн дотор Хороонд ирүүлэх;

4.4.10. кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдийн санхүүгийн байдалд сөргөөр нөлөөлж болох санхүү, эрх зүй, зах зээл, үйл ажиллагаа, нэр хүндийн зэрэг эрсдэлийн талаар Хороонд нэн даруй мэдэгдэх;

4.4.11. Үнэт цаасны зах зээлийн тухай болон Банкны тухай хууль тогтоомжид зааснаас гадна дараах мэдээллийг Хорооноос тогтоосон хавсралтын дагуу сар бүр гаргаж дараа сарын 25-ны өдрийн дотор Хороонд ирүүлэх:

4.4.11.1. харилцагчдыг талаарх тойм мэдээлэл;

4.4.11.2. үйлчилгээ үзүүлж буй хөрөнгийн тоо хэмжээ, үнийн дүн.

4.5. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь банкны хараат болон охин компани бол хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах, хуулийн этгээдийн оноосон нэрийг өөрчлөх, гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөхдөө тухай бүр Хороонд мэдэгдэж, зөвшөөрөл авна.

#### **Тав. Кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээ**

5.1. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь харилцагчтай үнэт цаас, мөнгөн хөрөнгө хадгалах болон хууль тогтоомж, энэ журмаар тогтоосон үйлчилгээг үзүүлэх гэрээ байгуулах замаар кастодианы үйлчилгээг үзүүлднэ.

5.2. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь энэ журмын 5.1-д заасан гэрээ байгуулалгүйгээр харилцагчид аливаа кастодианы үйлчилгээ үзүүлдэхийг хориглоно.

5.3. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь харилцагчтай гэрээ байгуулахдаа түүнд кастодианы үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг танилцуулах үүрэгтэй.

5.4. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь харилцагчийн нутаг дэвсгэрийн харьяалалаас үл хамааран кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулж болно.

5.5. Иргэний хууль, бусад холбогдох хууль тогтоомжид зааснаас гадна дараах зүйлийг гэрээнд заавал тусгана:

5.5.1. үзүүлж буй үйлчилгээний төрөл, хэлбэр, талуудын эрх, үүрэг;

5.5.2. үйлчилгээний шимтгэл, хураамжийн хэмжээ, түүнтэй холбоотой мэдээлэл;

5.5.3. нохон толбөр;

5.5.4. Хороо болон Мөнгөлбанкинд мэдээлэх үүрэг

5.5.5. гэрээг цуцлах журам;

5.5.6. харилцагчид хүргэх мэдээллийн төрөл, мэдээлэл хүргэх хэлбэр, давтамж;

5.5.7. харилцагчийн дансан дахь хөрөнгийг буцаан олгох, эсхүл өөр кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдэд шилжүүлэх тухай;

5.5.8. харилцагчийн хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, үнэт цаас болон мөнгөн хөрөнгийн тулгалт хийх тухай;

5.5.9. Гадаадын хөрөнгө оруулагчид төгрөгөөс бусад валютаар шилжүүлэг хийх тохиолдолд гадаад валютын хөрвүүлэг хийх тухай;

5.5.10. давагдашгүй хүчин зүйлийн нөхцлүүд;

5.5.11. хэрэглэх хууль тогтоомжийн хүрээ болон маргаан шийдвэрлэх журам.

5.6. Энэ журмын 5.7-д зааснаас бусад этгээдийн санаачлагаар кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээг цуцалсан тохиолдолд харилцагчаас бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн түүний дансан дахь аливаа өр төлбөр, сөрөг позицыг хаасны дараах хөрөнгийг ажлын 20 хоногт багтаан шинээр кастодианы үйлчилгээ үзүүлэх этгээд дэх тухайн харилцагчийн дансанд шилжүүлэх ажиллагааг гүйцэтгэнэ.

5.7. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдийн санаачлагаар гэрээг цуцалсан тохиолдолд гэрээнд заасны дагуу кастодианы үйлчилгээ үзүүлэх өөр этгээдэд харилцагчдын аливаа өр төлбөр, сөрөг позицыг хаасны дараах хөрөнгийг шилжүүлэх ажлыг энэ журмын 14 дүгээр зүйлд заасны дагуу хариуцан зохион байгуулна.

5.8. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь харилцагчийн үнэт цаасыг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага дээр хамтын номиналь дансанд, эсхүл зөвхөн тухайн харилцагчид зориулж нээсэн номиналь дансанд номиналь эзэмшигчийн хувиар хадгалж болно. Кастодианы удирддаг аливаа номиналь данс нь дараах шаардлагыг хангасан байна:

5.8.1. номиналь дансыг хадгалах, удирдах бодлого, журмыг кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээнд тусган харилцагчид танилцуулж харилцагчаар гарын үсэг зуруулан баталгаажуулна;

5.8.2. харилцагчийн хөрөнгийг номиналь эзэмшигч буюу кастодианы нэр дээрх хамтын номиналь дансанд дахь хадгалах бол харилцагчдын хөрөнгийг харилцагч бүрээр өөрийн дотоод бүртгэл, системд тодорхой ялган зааглаж тодорхойлно;

5.8.3. кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хөрөнгө, харилцагчдын хөрөнгийг хооронд нь тусгаарлах зорилгоор кастодианы хөрөнгө, харилцагчдын хөрөнгөд тус тус зориулсан хоёроос доошгүй хамтын номиналь дансыг төвлөрсөн хадгаламжийн байгууллагад нээж удирдана;

5.8.4. номиналь эзэмшигчийн нэр дээрх хамтын номиналь дансыг номиналь эзэмшигчийн дотоод бүртгэлд тусгагдсан харилцагч тус бүрийн эд хөрөнгөтэй тогтмол тулгалт хийнэ. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь энэхүү тулгалтыг 7 хоног тутам хийх ба богоод аливаа материаллаг зөрчлийг илрүүлсэн бол ийнхүү илрүүлснээс хойш хуанлийн долоо хоногийн дотор Хороонд мэдэгдэх үүрэгтэй.

5.8.5. хамтын номиналь дансыг зохицуулсан аливаа дүрэм, журам нь хууль тогтоомжид нийцсэн байна.

5.9. Харилцагч нь аливаа дүрэм, журам нь хууль тогтоомжид нийцсэн төвлөрсөн хадгаламжийн байгууллага дээр нээлтэй буюу шууд эзэмшлийн дансыг нээлгэж болно. Кастодианы үйлчилгээ үзүүлэх этгээд харилцагчийн нэрийн өмнөөс уг дансыг удирдахдаа дараах нөхцлүүдийг хангана. Үүнд:

5.9.1. Төвлөрсөн хадгаламжийн байгууллага дээр нээсэн нээлттэй буюу шууд эзэмшлийн дансны нэрийг дараах байдлаар бүртгэнэ. Үүнд: “харилцагчийн нэрийн өмнөөс кастодианы нэр” гэж (жишээ нь, “Иргэн ААА-ийн нэрийн өмнөөс БББ банкны удирдах данс”);

5.9.2. төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь дансыг бүрэн нэрлэгдсэн хэлбэрээр өөрийн нэр дээр нээлгэх шаардлагыг харилцагч тавьсан бол кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээнд дараах мэдээллийг заавал оруулсан байна:

5.9.2.1. бүрэн нэрлэгдсэн дансыг хадгалах, удирдах харилцагчийн эрх үүрэг;

5.9.2.2. тухайн дансны хадгалалт, удирдлага дахь кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдийн оролцооны хэр хэмжээ;

5.9.2.3. харилцагчийн өмнө хүлээх төвлөрсөн хадгаламжийн байгууллагын үүрэг;

5.10. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь харилцагчтай байгуулах гэрээний нөхцлөө өөрөө тодорхойлох эрхтэй бөгөөд уг гэрээний зохицуулалтад Хорооны зүгээс энэ журмын 5.5-т зааснаас бусад хэлбэрээр оролцохгүй.

### **Зургаа. Харилцагчийн дансан дахь хөрөнгийг бүртгэх, тулгах**

6.1. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь харилцагчийн хөрөнгийг өөрийн дотоод бүртгэлд балансын гадуур бүртгэх ба харилцагчийн данс, түүний бүртгэлтэй холбоотой дараах үүргийг биелүүлж ажиллана. Үүнд:

6.1.1. кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь өөрийн дотоод нягтлан бодох бүртгэлд харилцагч тус бүрийн нэр дээр тус тусад нь данс нээх ба уг дансны гүйлгээний бүртгэлийг кастодианы нягтлан бодох бүртгэлд мөрдөх олон улсын мэргэжлийн стандартад нийцүүлэн гүйцэтгэх;

6.1.2. кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж буй гадаад улсын кастодианы харилцагчийн эзэмшдэг, Монгол Улсад бүртгэлтэй үнэт цаасыг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад тус гадаад улсын кастодианы нэр дээр, эсхүл түүний харилцагчийн нэр дээр данс нээх замаар үйлчилгээ үзүүлнэ. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь энэ журмын 7.7 дахь заалтын дагуу гадаадын хөрөнгө оруулагч, түүний кастодианы талаарх бүхий л шаардлагатай мэдээллийг цуглуулж хадгалах ;

6.1.3. харилцагчийн мөнгөн хөрөнгө, үнэт цаасны бүртгэлийн найдвартай байдлыг хангах зорилгоор Монгол Улсад бүртгэлтэй үнэт цаасны хувьд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь, гадаад улсад бүртгэлтэй үнэт цаасны хувьд гадаад улсын кастодиан дахь холбогдох бүртгэл, баримттай тулгах замаар шалгах;

6.1.4. энэ журмын 6.1.3-г заасан тулгалтыг хийхдээ холбогдох хууль тогтоомж, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаас гаргасан журамд шийцүүлэн гүйцэтгэх.

6.2. Гадаад улсын кастодиан нь энэ журмын 7.7 дахь заалтын дагуу нь кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдийг шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй.

6.3. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд төвлөрсөн хадгаламжийн байгууллагатай хамтран харилцагчийн дансан дахь хөрөнгийн тулгалтыг 7 (долоо) хоног тутам хийх ба ийнхүү тулгасны эцэст харилцагчийн хөрөнгийг тулгасан тухай акт үйлдэнэ. Уг актад номиналь данс, эсхүл нээлттэй дансанд илэрсэн зөрүүг тусгаж, үүнийг хэрхэн шийдвэрлэсэн тухай мэдээллийг заавал тусгана.



6.4. Тулгалт хийсэн тухай актыг 2 хувь үйлдэх бөгөөд талууд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна.

6.5. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд гадаад улсын кастодиан, эсхүл гадаад улсын төвлөрсөн хадгаламжийн байгууллагатай тулгалт хийхдээ гэрээнд заасан олон улсын банк хоорондын мэдээлэл дамжуулах системийг ашиглах ба кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдийн дотоод бүртгэл дэх харилцагчийн дансан дахь үнэт цаас, мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тулгалт хийх өдрийн байдлаар тодорхойлно.

6.6. Тулгалт хийхэд ашигласан баримт бичиг, системээр дамжуулан авсан мэдээллийг төвлөрсөн хадгаламжийн байгууллага руу шилжүүлж, тулгалт хийсэн өдрөөс хойш 10-аас доошгүй жил хадгална.

6.7. Энэ журамд заасан тулгалтын эцэст харилцагчийн дансан дахь үлдэгдэл хөрөнгийн дүнд зөрүү гарсан тохиолдолд талууд гарсаа зөрүүг арилган, үлдэгдлийг тааруулах арга хэмжээ авах үүрэгтэй.

6.8. Харилцагчийн дансан дахь үлдэгдэл хөрөнгийн дүнд гарсан зөрүүг арилгах боломжгүй бөгөөд дараагийн тулгалтын акт гарах хүртэл үргэлжлэх хандлагатай тохиолдолд зөрүүний тухай Хороо, Монголбанк, төвлөрсөн хадгаламжийн байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

6.9. Төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд энэхүү журамд заасан тулгалтыг хийхэд шаардлагатай мэдээллийг саадгүй авах нөхцлийг бүрдүүлж ажиллана.

#### **Долоо. Дансны төрөл**

7.1. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь үнэт цаасны төвлөрсөн бүртгэлд үнэт цаасны нэгдсэн бүртгэлийг тусгах ба кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд дэх үнэт цаасны өмчлөх эрхийн тухайлсан бүртгэлд эзэмшлийг бенефициар өмчлөгч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч тус бүрийн хөрөнгийг бүртгэнэ.

7.2. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь дараах дансны төрөлтэй байна:

7.2.1. Нээлттэй буюу шууд эзэмшлийн данс (“fully disclosed account”): Уг дансыг эзэмшигч нь бенефициар өмчлөгч байх ба түүний нэр дээр нээлттэй мэдээлэл бүхий данс пээнэ. Уг дансны эзэмшигчийн мэдээлэл нь бенефициар өмчлөгчийн мэдээлэл байна;

7.2.2. Номиналь данс буюу шууд бус эзэмшлийн данс (“nominee account”): Кастодиан нь бусдын нэрийн өмнөөс уг дансыг удирдаж, номиналь дансны эзэмшигчийн мэдээлэлд бенефициар өмчлөгчийн бус, номиналь эзэмшигчийн мэдээллийг тусгана. Номиналь данс эзэмшигч нь үнэт цаасыг эзэмших, холбогдох гүйлгээг гүйцэтгэх, бенефициар өмчлөгч, эсхүл түүний төлөөлөгчөөс ирүүлсэн зааврыг мөрдөнө;

7.2.3. Холимог данс (“mixed account”). Энэ нь номиналь дансны нэг төрөл ба уг дансны эзэмшигчийн мэдээлэлд бенефициар өмчлөгчийн мэдээллийг тусгах боловч номиналь эзэмшигч нь бенефициар өмчлөгчөөс өгсөн даалгаваргүйгээр бенефициар өмчлөгчийн нэрийн өмнөөс гүйлгээг хийхийг зөвшөөрнө;

7.2.4. Итгэмжлэгдсэн данс ("trustee account"). Итгэмжлэгдсэн дансыг бенефициар өмчлөгчийн нэрийн өмнөөс итгэмжлэгдсэн төлөөлөгч удирдана. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг дансыг бенефициар өмчлөгчөөс өгсөн тодорхой заавар, чиглэлгүйгээр бие даан, тухайн өмчлөгчийн ашиг сонирхолд нийцүүлэн удирдана.

7.3. Нээлтэй данс нь дараах мэдээллийг агуулна:

7.3.1. дансыг бенефициар өмчлөгчийн нэр дээр нээх ба бенефициар өмчлөгчийн овог, эцгийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа хаяг, утасны дугаар, электрон шуудан, харьяалагдах татварын байгууллага, гэр бүлийн байдал, хүүхдийн тоо, санхүүгийн эх үүсвэр, иргэний үнэмлэхний хуулбар, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний болон регистрийн дугаар, гарын үсэг зурах эрх бүхий этгээд;

7.3.2. Итгэмжлэл буюу байнгын зааварчилгаагаар бенефициар өмчлөгч нь өөрийн нэрийн өмнөөс нээлтэй дансыг удирдах төлөөлөгчийг томилох ба дансан дахь үнэт цаас нь гагцхүү бенефициар өмчлөгчийн өмч байх ба төлөөлөгч нь бусдын нэрийн өмнөөс дансыг удирдахад мэргэшсэн, зөвшөөрөгдсөн байх ёстой.

7.4. Номиналь данс нь дараах онцлогтой байна:

7.4.1. дансыг удирдах номиналь эзэмшигч нь кастодианы үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий хуулийн этгээд байна;

7.4.2. бенефициар өмчлөгч нь кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээгээр номиналь данс эзэмшигчийг томилно;

7.4.3. номиналь данс эзэмшигч /кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд/ нь өөрийн дотоод данс бүртгэлдээ бенефициар өмчлөгч тус бүрд энэхүү журмын 7.3.1-д заасан мэдээллийг агуулсан данс нээнэ;

7.4.4. номиналь данс эзэмшигч /кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд/ нь дотоод данс бүртгэлийг хөтлөхдөө хамтын номиналь данс дахь бенефициар өмчлөгчийн хөрөнгийг бусад өмчлөгчдийн хөрөнгийн нэгдсэн бүртгэлтэй тулгалт хийж байна.

7.5. Холимог номиналь данс нь номиналь данстай адил нөхцөлтэй байх боловч бенефициар өмчлөгчийн нэр дээр давхар бүртгэлтэй байна. Уг данс нь нээлттэй дансны адилаар бенефициар өмчлөгчийн тухай бүрэн мэдээллийг агуулсан байх бөгөөд кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд зөвхөн уг дансыг удирдана.

7.6. Итгэмжлэгдсэн дансыг бенефициар өмчлөгч болон түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хооронд байгуулсан гэрээнд заасан нөхцөл журмын дагуу нээж удирдана. Тус гэрээнд талуудын (толоолгогч, төлөөлүүлэгч) харилцан хүлээх үүрэг, эдлэх эрхийг тодорхой тусгана. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь өөрийн дотоод бүртгэлд энэ журмын 7.3-т заасан мэдээллийг агуулсан дансыг бенефициар өмчлөгч тус бүрээр нээж хөтлөх ба хамтын номиналь данс дахь бенефициар өмчлөгчийн хөрөнгийг бусад өмчлөгчдийн хөрөнгийн нэгдсэн бүртгэлтэй тулгалт хийж байна. Номиналь данс эзэмшигч /кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд/ нь дотоод данс бүртгэлийг хөтлөхдөө хамтын номиналь данс дахь бенефициар өмчлөгчийн хөрөнгийг бусад өмчлөгчдийн хөрөнгийн нэгдсэн бүртгэлтэй тулгалт хийнэ.

7.7. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь энэ журмын 7.2-т заасан дансуудын хувьд терроризмыг санхүүжүүлэх, мөнгө угаах, эдийн засгийн бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх

болон харилцагчийн толборөө төлөх чадварыг баталгаажуулах үүднээс харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг зохистой түвшинд дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:

7.7.1. харилцагчийг таньж мэдэх ажлын гүйцэтгэхдээ холбогдох кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5.3-т заасан журмыг мөрдөнө;

7.7.2. харилцагчийн хуучин мэдээлэл бүхий дансыг нь ашиглан бенефициар өмчлөгчийн данс нээж болно;

7.7.3. Олон Улсын Санхүүгийн Гэмт Хэрэгтэй Тэмцэх Байгууллага (FATF) /цаашид “ОУСИХТБ” гэх/-ын зөвлөмжөөр харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг эрсдэлд суурилсан аргын дагуу гүйцэтгэж, эрсдэлийн түвшнээс хамаарч дараах гурван түвшинд хийнэ:

7.7.3.1. эрсдэл багатай харилцагчийн хувьд таньж мэдэх ажиллагааг хялбаршуулсан түвшинд хийнэ;

7.7.3.2. хэвийн түвшний харилцагчийн хувьд таньж мэдэх үйл ажиллагаа нь гарын үсэг зурсан анкет, бенефициар өмчлөгчийн иргэний үнэмлэхний хуулбар, оршин суугаа газрын тодорхойлолт, мөнгөн хөрөнгийн гарал үүслийн тодорхойлолт, хуулийн этгээдийн хувьд бенефициар өмчлөгчийн гарын үсэг бүхий жагсаалт, мөн нэр тус бүрээр паспортын хуулбар, мөнгөн хөрөнгийн гарал үүслийн тодорхойлолт, Монголбанкнаас шаардсан бусад бичиг баримт;

7.7.3.3. улс төрд нөлөө бүхий этгээд, эсхүл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж тодорхойлогдсон улсад оршил суугч, эсхүл газар зүйн хувьд алслагдмал бүсэд оршин суугч зэрэг өндөр эрсдэл бүхий харилцагчийн хувьд таньж мэдэх дараах ажиллагааг явуулна. Үүнд:

7.7.3.3.1. энэ журмын 7.7.3.2-т заасан бичиг баримтын апостиль нотариатаар гэрчлүүлсэн хувь, бусад нэмэлт мэдээлэл, мэргэжлийн тодорхойлолт, ял шийтгэлийн талаарх тухайн орны цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

7.7.3.3.2. харилцагч нь гадаад улсын санхүүгийн байгууллага бол тухайн санхүүгийн байгууллагын бенефициар өмчлөгчийг таньж мэдэх ажиллагааг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:

7.7.3.3.2.1. гадаад улсын санхүүгийн байгууллагын мөнгө угаах, терроризмтай тэмцэх тухай ажиллагаанд тухайн орны холбогдох эрх бүхий байгууллагаас зохистой хяналтыг тавьдаг эсэх (“equivalent supervision” зарчим);

7.7.3.3.2.2. кастодианы үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий этгээд нь бенефициар өмчлөгчийг таньж мэдэх ажиллагааг гадаад улсын санхүүгийн тухайн байгууллагаар гүйцэтгүүлж болох боловч ийнхүү таньж мэдэх ажиллагааг зохих журмаар явуулах үүргийг Монголбанк болон Хорооны өмнө өөрөө хариуцна.

7.8. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий этгээд нь гадаад улсын санхүүгийн байгууллагын нэр дээр данс нээхдээ кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээнд бенефициар өмчлөгчийг таньж мэдэх талаар тухайн санхүүгийн байгууллагын (номинал эзэмшигчийн) хүлээх үүрэг, хариуцлагыг тусгаж баталгаажуулна.

7.9. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь Мөнгө угаах болон терроризмтай тэмцэх тухай хууль, уг хуульд нийцүүлэн Монголбанкнаас байгууллагын бүтэц, боловсон хүчин, үйл ажиллагаанд тавьсан шаардлагыг хангаж ажиллана.

## Найм. Кастодианы үйлчилгээний дэд бүтэц

8.1. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь уг үйл ажиллагааг найдвартай, мэргэжлийн түвшинд гүйцэтгэх ба дараах шаардлагыг хангах дэд бүтцийг бүрдүүлсэн байна.

8.2. Аюулгүй, найдвартай ажлын байртай байх. Үүнд:

8.2.1. ус, галын аюул болон цаг агаарын онцгой байдал, гадны халдлага зэргээс үүсэх хохирол, гэмтлээс хамгаалагдсан газарт, хаалга, цонх болон цоож түгжээ нь хангалттай баг бөх барилга байгууламжид байрших;

8.2.2. олон улсын стандартад пийцсэн хангалттай гэрэлтүүлэгтэй, цахилгаан, эрчим хүчний саатал гарсан тохиолдолд кастодианы үйл ажиллагааг тасралтгүй явуулах цахилгааны үүсгүүр /генератор/-тэй байх;

8.2.3. бүх төрлийн галын аюул, огцом халах эсхүл хүйтрэх, ус алдах гэх зэрэг онцгой нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх үүднээс мэдрэгчтэй дохиоллын систем, температурын тохируулга, галын дохиолол, ус шүршигч болон гал унтраагч зэрэг тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байх;

8.2.4. нэг ажилтанд ногдох талбай нь 6-аас багагүй квадрат метр байх ба ширээ, сандал, тохиромжтой гэрэлтүүлэг, телефон утас, компьютер болон бусад албан ажилд шаардлагатай хэрэгслээр хангагдсан байх;

8.3. мэдээллийн технологи, харилцаа холбооны аюулгүй, найдвартай, бүрэн тоноглогдсон орчин бүрдүүлсэн байх. Үүнд:

8.3.1. бүх компьютер, харилцаа холбооны тоног тохооромжид зориулагдсан

8.3.2. компьютерийн өрөөг стандартын дагуу тоноглох. Тухайлбал, аюулгүй найдвартай ажиллагааны дагуу өндөрсгөсөн шал, температурын тохируулга, зохистой агааржуулагч, галд тэсвэртэй түгжигддэг хаалгатай бөгөөд цонхгүй байх;

8.3.3. телефон утас болон мэдээлэл дамжуулагч шугам сүлжээг найдвартай, тогтвортой харилцаа холбооны компаниар гүйцэтгүүлэх ба “програм хангамжид суурилсан” болон “техник хангамжид суурилсан” галт хана /“firewall”/-тай байх;

8.3.4. Монголбанк, хөрөнгийн бирж болон үлэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагатай холбогдсон харилцаа холбооны хэрэгслийн холболт нь аюулгүй, найдвартай байх, мэдээлэл дамжуулах явцад мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг олон улсын стандартад нийцүүлэх;

8.3.5. цахилгааны хэлбэлзлээс хамгаалах үүднээс цахилгаан хүчдэл тогтворжуулагчтай байх ба төв компьютер болон харилцаа холбооны төхөөрөмж нь 4-өөс доошгүй цаг ажиллах эрчим хүчээр тогтвортой хангагчтай байх;

8.3.6. төв систем буюу тусгай програм хангамж, архивлагдсан баримт бичиг, дотоод сүлжээний цахим шуудан нь кастодианы үйл ажиллагааны нэгжээс тусдаа өөр газарт байрших компьютерт давхар хадгалагдсан байх ба давхар хадгалах хэрэгсэл нь уг газраас гадуур аюулгүй газарт байрших аюулгүй барилга, байгууламжид галд тэсвэртэй сейфэнд хадгалагдсан байх;

8.4. хэвийн, найдвартай үйл ажиллагаа явуулах програм хангамжийн орчин бүрдүүлсэн байх. Үүнд:

8.4.1. програм хангамжийг алиглахад зориулсан тусгай төв компьютер нь хангалттай хурд, санах ой, хамгаалалт (“програм хангамжид суурилсан” галт хана)-тай байх;

8.4.2. 50 болон түүнээс доошгүй тооны харилцагчдад зориулсан сервер, интернетэд нэвтрэх боломж, баримт бичиг хадгалах зай ба цахим шуудантэй байх;

8.4.3. ажилтан тус бүр өөрийн хангалттай хурд, хадгалах зай бүхий Microsoft Office болон кастодианы програм ажлуулж чадахуйц компьютертэй байх бөгөөд USB оролт, CD/DVD уншигч болон бусад бүх төрлийн гаралтын хэрэгсэл нь түгжигдсэн, зовхоо мэдээлэл, технологийн администратор нэвтрэх эрхтэй байх;

8.5. кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд, кастодианы үйл ажиллагаа эрхлэх нэгж нь дараах програм хангамжийг ашиглах боломжтой байх:

8.5.1. сервер компьютерт зориулсан үндсэн програм хангамж /windows, эсхүл бусад түгээмэл үйлдлийн систем/;

8.5.2. зохистой хамгаалалтын програм хангамжтай байх ба энэ нь харилцагчийн удирдлагын програм хангамж, галт хана, антивирусын програм ба төв компьютерийн хамгаалалтыг сайжруулах өөр програм хангамжийг багтаасан байна;

8.5.3. харилцаа холбооны програм хангамж нь харилцаа холбооны хэрэгсэлд найдвартай нэвтрэх боломжтой байх ба үүнд, кастодианы нэгж хоорондын LAN оролт, SWIFT, хөрөнгийн бирж, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага болон Монголбанкны гүйлгээний үйл явц, тайлагналын систем, интернет, цахим шууданг холбогдсон байна;

8.5.4. төв компьютерт суулгах оффисын програм нь цахим шуудан удирдах, баримт бичгийг хадгалах, календарь болон бусад шаардлагатай энгийн оффис програмтай байх;

8.5.5. төв компьютерт кастодианы удирдлагын програмыг суулгасан байх; энэхүү програм нь багц, эсхүл байгууллагын оюуны омч /proprietary/байж болно; кастодианы үйл ажиллагаа явуулахад шаардлагатай функцтэй байх (тухайлбал, үнэт цаасны мэдээллийн сан, харилцагчийн мэдээллийн сан, данс удирдах програм, харилцагчаас өгөх зааварчилгааг боловсруулах, удирдах аппликейшн г.м.);

8.5.6. мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэслэлээр мэдээлэл дамжуулахдаа нууцлалын технологи ашиглах.

8.6. Кастодианы үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх төлөвлөгөөг боловсруулж мөрдүүлэх. Үүнд:

8.6.1. Кастодианы үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх төлөвлөгөө нь кастодианы үйлчилгээг хэвийн, тогтвортой үргэлжлүүлэхэд чиглэж, үүнтэй холбоотой бүхий л асуудлыг хамарсан байх;

8.6.2. Кастодианы үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх төлөвлөгөө нь компьютер, бусад техник хангамж, мэдээлэл, харилцаа холбоо, факс, принтер, ажилтан зэрэг Кастодианы үйл ажиллагаа эрхлэх нэгжийн үйл ажиллагааны бүхий л хүрээг хамарсан байх;

8.6.3. Кастодианы үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх төлөвлөгөөг тогтмол шинэчилж байх;

8.6.4. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх нэгж дээр хийх аудитын хүрээнд хянаж шалгадаг байх;

8.6.5. Кастодианы үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх төлөвлөгөөг жилд нэгээс доошгүй удаа заавал туршиж шалгадаг байх. Ийнхүү туршихад ажилтнуудад урьдчилан мэдэгдэхийг хориглох ба туршилтын үр дүнг тусгасан тайланг бэлтгэж, Хороонд ирүүлэх;

8.7. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх нэгж дээр гүйцэтгэдэг бүхий л ажиллагааг (ялангуяа мэдээллийн технологитой холбоотой ажиллагааг) дэлгэрэнгүй журам, горим, зааварт тодорхой тусгах. Эдгээр журам, горим, зааварт дараах шаардлагыг тавина. Үүнд:

8.7.1. тогтмол шинэчилж байх;

8.7.2. кастодианы үйл ажиллагаа эрхлэх нэгжийн бүх ажилтанд танилцуулах, тэдэнд хүртээмжтэй байлгах;

8.7.3. кастодианы үйл ажиллагаа эрхлэх нэгжийн жилийн тайланд тусгах.

#### **Ес. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдийн удирдлага, зохион байгуулалт, тэдгээрт тавигдах шаардлага**

9.1. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдийн удирдах дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

9.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт түүнээс сонгогдсон төлөөлөн удирдах зөвлөл удирдана.

9.3. Кастодианы үйл ажиллагааг банк болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага гүйцэтгэж байгаа бол Банкны тухай хууль болон Компанийн тухай хуульд заасан шаардлага хангасан төлөөлөн удирдах зөвлөлтэй байна.

9.4. Кастодианы үйл ажиллагааг банкны хараат болон охин компани гүйцэтгэж байгаа бол тухайн компани нь 3 болон түүнээс доошгүй гишүүнтэй төлөөлөн удирдах зөвлөлтэй байх бөгөөд тэдгээрийн нэгээс доошгүй нь Компанийн тухай хууль болон Банкны тухай хуульд заасан төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнтэй байна.

9.5. Банк кастодианы үйл ажиллагааг эрхлэх тохиолдолд кастодианы үйл ажиллагаа эрхлэх нэгжийн удирдах байгууллага нь банкны удирдлага байх бөгөөд банкны удирдлагын хороо нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдаж, кастодианы үйл ажиллагааны тайланг хэлэлцэнэ.

9.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

9.7. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь энэ журмын 2.2.6-д заасны дагуу 6-аас доошгүй мэргэжлийн үндсэн ажилтантай байна.

9.8. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь кастодианы үйл ажиллагаа, зорилгод нийцүүлэн хэрэгжүүлэх боловч хүний нөөц, удирдлагын хувьд дараах жишиг бүтцийг баримталбал зохино:

9.8.1. кастодианы үйл ажиллагааг бүхэлд нь хариуцах ба санхүүгийн мэргэжилтэй, энэ чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай захирал, эсхүл менежер удирдах бөгөөд дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

9.8.1.1. кастодианы үйлчилгээг үр ашигтай ажиллуулах;

9.8.1.2. бодлого төлөвлөлт, дүрэм журам болон кастодианы үйл ажиллагааны нэгжийн гүйцэтгэх ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх;

9.8.1.3. ажилтнуудыг удирдах ба төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэх.

9.8.2. мэдээллийн технологи хариуцсан менежер дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

9.8.2.1. кастодианы үйл ажиллагааны техник хангамж, програм хангамж, харилцаа холбоо, компьютерийн хэвийн үйл ажиллагааг хангах;

9.8.2.2. мэдээллийн технологийн эрсдэл болон аюулгүй байдлыг хангах;

9.8.2.3. мэдээлэл технологийн төсөв болон зардлыг удирдах;

9.8.2.4. кастодианы үйл ажиллагааны мэдээлэл, технологийн програм нь толгой компани /банк/-ийн мэдээллээс тусдаа байлгах.

9.8.3. Кастодианы үйлчилгээний мэргэжилтэн нь санхүүгийн мэргэжилтэй, мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан этгээд байх бөгөөд дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

9.8.3.1. кастодианы үйлчилгээ, харилцагчийн даалгаврыг гүйцэтгэх;

9.8.3.2. компанийн үйл ажиллагааг гүйцэтгэх, төлбөр хийх, тайлан гаргах, түүнийг холбогдох этгээдэд тайлагнах;

9.8.3.3. татвартай холбогдолтой үйлчилгээ үзүүлэх, ёс зүйг баримтлах;

9.8.3.4. кастодианы үйлчилгээтэй холбогдсон гэрээнд заасан бусад чиг үүрэг.

9.8.4. харилцагчид үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн нь дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

9.8.4.1. харилцагчтай харилцах ажлыг гүйцэтгэж, харилцагчдад үр ашигтай үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх;

9.8.4.2. харилцагчдын асуулталд шуурхай, үнэн зөв хариулах, холбогдох мэдээллээр хангах;

9.8.4.3. харилцагчдын аливаа санал, хүсэлтийг хүлээн авах, түүнийг үр дүнтэй шийдвэрлэх, холбогдох этгээдэд мэдээлэх, шаардлагатай тайлан, мэдээллийг хүргэх.

9.8.5. кастодианы үйл ажиллагааны туслах ажилтан нь дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

9.8.5.1. кастодианы үйл ажиллагаатай холбоотой маягт бэлдэх, харилцагчдаас санал, хүсэлт хүлээн авч харилцагчид үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэнд хүргэх, баримт бичгийг хувилах, архив хөтлөх;

9.8.5.2. кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээ болон бусад холбогдох баримт, материалын хадгалалт, хамгаалалтыг хариуцах;

9.8.5.3. кастодианы үйл ажиллагаа эрхлэх нэгж, энэ журмын 9.8.1-9.8.4-т заасан этгээдэд шаардлагатай туслах чиг үүргийг гүйцэтгэх.

9.9. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь эрсдэлээс өөрийгөө хамгаалж чадахуйц даатгалтай байх ёстой.

### **Арав. Эрсдэлийн удирдлагад тавигдах шаардлага**

10.1. Кастодианы үйл ажиллагаанаас санхүүгийн системд үүсч болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор Монголбанкнаас тогтоосон хувиар кастодианы үйл ажиллагаа явуулж буй этгээд хадгалсан үнэт цаасны үнийн дүнгээс сан байгуулж Монголбанкны тусгай дансанд байршуулна.

10.2. Кастодианы үйл ажиллагаа явуулж буй этгээд сангийн тохируулгын гүйлгээг сар бүрийн эцэст гүйцэтгэнэ.

10.3. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын албыг байгуулах ба уг алба нь дараах үүргийг хэрэгжүүлнэ:

10.3.1. Кастодиан үйлчилгээний эрсдэлийн удирдлагын тайланг байгууллагын удирдлагад танилцуулж байх;

10.3.2. уг албыг байгууллагын холбогдох удирдах албан тушаалтнаар удирдуулах;

10.3.3. кастодианы үйлчилгээ үзүүлдэг этгээдэд учирч болох бусад бүх торлийн (зах зээлийн эрсдэл, зээлдүүлэгчийн эрсдэл, харилцагчийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл) эрсдэлийн удирдлага, бодлогыг бий болгож мөрдөх;

10.3.4. олон улсын туршлагад нийцсэн эрсдэлийн үнэлгээ (VaR), стресс тест зэрэг тоон болон чанарын аргачлал бүхий эрсдэлийн удирдлагын тогтолцоотой бий болгож, мөрдөх;

10.3.5. эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг удирдах болон бууруулах, эрсдэлийг мэдээлэх, эрсдэлтэй харьцах, эрсдэлд хяналт тавих гэсэн дамжлага бүхий эрсдэлийн боллого, удирдлагатай байх;

10.3.6. эрсдэл болон түүнээс үүдэн гарсан алдагдал үүсэн талаарх түүхэн мэдээллийг хадгалах;

10.3.7. эрсдэлийн удирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл, ноод бололцоог хангаж ажиллах;

10.3.8. эрсдэлийн мэдээллийн санд тулгуурлан эрсдэлийн тайланг гаргаж үүнийг кастодианы эрсдэл хариуцсан албаар баталгаажуулан улирал бүр Хороонд хүргүүлж байх;

#### **Арван нэг. Кастодианы үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах хязгаарлалт ба хориглох зүйлс**

11.1. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үйл ажиллагаанд хууль тогтоомжид зааснаас гадна дараах зүйлийг хориглоно:

11.1.1. харилцагч, түүний төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр түүний дансан дахь үнэт цаас, мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах;

11.1.2. харилцагчийн мөнгөн хөрөнгө, үнэт цаасыг өөрийн мөнгөн хөрөнгө, үнэт цаастай хамт нэг дансанд хадгалах, нэг харилцагчийн мөнгөн хөрөнгө, үнэт цаасыг бусад харилцагчийн мөнгөн хөрөнгө, үнэт цаастай хамт нэг дансанд хадгалах;

11.1.3. кастодианы үйлчилгээ үзүүлэх явцад олж авсан пууцын зэрэглэлтэй болон дотоод мэдээлэл, тайлан, баримт бичгийг найдвартай хадгалан хамгаалж, зөвхөн эрх бүхий байгууллагаас шаардсанаас бусад тохиолдолд аливаа гуравдагч этгээдэд задруулах;

11.1.4. харилцагчийн нэр, түүний данстай холбоотой өгөгдөл, мэдээллийг бусдад тараах, мэдээлэх;

11.1.5. кастодианы данстай холбоотой өгөгдөл, мэдээллийг бусдад тараах,

11.1.6. брокер дилерийн үйл ажиллагаа эрхлэх;

11.1.7. хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагаас хориглосон бусад үйл ажиллагаа.

#### **Арван хоёр. Кастодианы үйл ажиллагааны тайлагнал**

12.1. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь өөрийн компанийн үйл ажиллагааны нэгжийн жилийн тайланг компанийн дотоод аудитын хороо, ГУЗ-өөр баталгаажуулж, дараа жилийн эхний улиралд багтаан Хороонд ирүүлэх ба жилийн тайлан нь дараах мэдээллийг агуулсан байна:

12.1.1. кастодианы тайлант хугацаан дахь бүхий л үйл ажиллагаа;

12.1.2. кастодианы үйл ажиллагааны үр дүнг тусгасан санхүүгийн жилийн тайлан, түүний дэлгэрэнгүй тайлбар, тодруулга;



- 12.1.3. кастодианы бүх төрлийн үйлчилгээний талаарх мэдээлэл;
- 12.1.4. шийт харилцагчдын тоо, тэдгээрийн бүтэц;
- 12.1.5. компанийн, эсхүл нэгжийн хэсэгчилсэн санхүүгийн тайлан;
- 12.1.6. компанийн санхүүгийн байдал, нэр хүнд болон санхүүгийн байдал;
- 12.1.7. компани, эсхүл нэгжтэй холбоотой ор толбөр, бусдын өмнө хүлээсэн үүрэг;
- 12.1.8. дотоод хяналтын тогтолцоо, түүний үр ашигтай байдлын талаар хөндлөнгийн аудитын байгууллагаас гаргасан дүгнэлт;
- 12.1.9. их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар;
- 12.1.10. банк бол засаглалын зарчим, түүний хэрэгжилтийн талаар;
- 12.1.11. компанийн, эсхүл нэгжийн үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээлэл.

**Арван гурав. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай  
зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох**

13.1. Хороо дараах үндэслэлээр кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ:

13.1.1. энэ журамд заасан мэдээллийг 3-аас дээш удаа ирүүлээгүй, тайлагнаагүй буюу мэдээлээгүй;

13.1.2. Хороо, бусад холбогдох байгууллагад ирүүлбэл зохих санхүүгийн тайлан, мэдээг хууль тогтоомжид заасан хугацаанд 2 улирал дараалан ирүүлээгүй;

13.1.3. Хорооноос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тогтоосон хугацаанд төлөөгүй 3 сар болсон;

13.1.4. харилцагчийн үнэт цаас, мөнгөн хорооноос бүртгэлийг холбогдох журмын дагуу хөтлөөгүй, тулгалт хийгээгүйгээс бий болсон алдааг нуун дарагдуулсан;

13.1.5. олон шийтийг төөрөгдүүлсэн зар сурталчилгаа, хуурамч мэдээлэл удаа дараа тараасан нь нотлогдсон;

13.1.6. кастодианы үйлчилгээг энэ журмын дагуу үзүүлэх боломжгүй болсон нөхцөл байдал бий болсон;

13.1.7. кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээг ноцтой зөрсөн;

13.1.8. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

13.2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тохиолдолд түдгэлзүүлсэн үндэслэл болон зөрчил дутагдлыг арилгаж, хэвийн үйл ажиллагааг хангасан гэж үзвэл тухайн этгээд тусгай зөвшөөрлөө сэргээлгэх хүсэлтийг Хороонд гаргаж болно.

13.3. Хороо дараах үндэслэлээр кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

13.3.1. кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд хүсэлт гаргасан;

13.3.2. Монголбанкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;

13.3.3. кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд Хорооноос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 1 жилээс дээш хугацаанд төлөөгүй;

13.3.4. Хороо болон Монголбанкнаас тогтоосон заавал байлгах өөрийн хөрөнгийн доод хэмжээ, үйл ажиллагааны эрсдэлийн сангийн зохистой хэмжээ болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуурыг 2 улирал дараалан хангаж ажиллаагүй;

13.3.5. кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд Хороо тусгай зөвшөөрөл олгосноос хойш 1 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй;

13.3.6. ирүүлбэл зохих санхүүгийн тайлан мэдээг 2 улирал дараалан Хороонд гаргаж өгөөгүй;

13.3.7. Хорооноос тусгай зөвшоорол авахдаа хуурамч баримт бичиг ашигласан нь илэрсэн;

13.3.8. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, энэ хугацаанд тухайн үйл ажиллагааг үргэлжлүүлэн эрхэлсэн, гаргасан зөрчлөө бүрэн арилгаагүй;

13.3.9. кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд дампуурсан тухай шүүхээс зарласан;

13.3.10. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

13.4. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, “ХҮЧИНГҮЙ” тэмдэг дарж тухайн байгууллагын хувийн хэрэгт хавсарган, холбогдох журмын дагуу архивт шилжүүлнэ.

13.5. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд Хороо, үнэт цаасны хадгаламжийн байгууллага болон тухайн кастодианы үйл ажиллагаа эрхлэх байгууллагатай хамтарсан Ажлын хэсэг гарган кастодианы үйл ажиллагаа болон харилцагчидтай холбоотой баримт бичиг, тайлан, мэдээ, мэдээллийг тусгай зөвшөөрөл бүхий өөр кастодианы үйл ажиллагаа эрхлэх байгууллагад холбогдох журмын дагуу шилжүүлнэ. Өөр кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдэд шилжүүлэх боломжгүй баримт бичиг, тайлан, мэдээ, мэдээллийг Хорооны архивт шилжүүлнэ.

13.6. Хороо кастодианы үйл ажиллагаа эрхлэхээр олгосон тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн болон хүчингүй болгосон тохиолдолд энэ тухай кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдэд ажлын 3 хоногт холбогдох шийдвэрийг хүргүүлэх ба олон нийтэд мэдээлнэ.

13.7. Тусгай зөвшоорол нь хүчингүй болсон кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдийн нэрийг тухайн хуулийн этгээдэд ажиллаж байсан этгээд болон өөр бусад хуулийн этгээд ашиглахыг хориглоно.

#### **Арван дөрөв. Харилцагчийн хөрөнгийг өөр кастодиванд шилжүүлэх**

14.1. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх банкнаас бусад этгээд нь төлбөрийн чадваргүй болсон, татан буугдсан, дампуурсан, өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд түүний хөрөнгийг кастодианы үйл ажиллагаа эрхлэх өөр этгээдэд Хорооны зөвшөөрлөөр шилжүүлэх бөгөөд ингэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

14.1.1. шилжүүлж буй хөрөнгийн жагсаалт;

14.1.2. шилжүүлж буй баримт бичгийн жагсаалт;

14.1.3. харилцагчийн дагсаан дахь үнэт цаасны бүртгэлийн жагсаалтыг харилцагч тус бүрээр;

14.1.4. харилцагчтай байгуулсан гэрээг харилцагч тус бүрээр;

14.1.5. хөрөнгө болон баримт бичгийг хүлээлцсэн тухай акт;

14.1.6. бусад шаардлагатай баримт бичиг.

14.2. Кастодианы үйл ажиллагаа эрхлэж буй банк нь төлбөрийн чадваргүй болсон, татан буугдсан, өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд харилцагчийн үнэт цаасны хадгаламжийг

кастодианы үйл ажиллагаа эрхлэх бусад этгээдэд Хорооны зөвшөөрлөөр шилжүүлэх бөгөөд ингэхдээ энэ журмын 14.1.1.-14.1.6-д заасан баримт бичгийг бүрдүүлнэ.

14.3. Энэ журмын 14.1.1-д заасан шилжүүлж буй хөрөнгийн жагсаалтад кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, хадгалалтад байгаа харилцагчаас шилжүүлсэн бүх хөрөнгө хамаарна.

14.4. Энэ журмын 14.1.2-д заасан жагсаалтад дараах баримт бичиг хамаарна:

14.4.1. үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь болон кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдийн дотоод бүртгэл дэх харилцагчийн дансны хуулгууд хөрөнгө шилжүүлэх өдрийн байдлаар;

14.4.2. кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага болон харилцагчтай хөрөнгө шилжүүлэх өдөр тулгалт хийсэн тухай акт, тулгалт хийхэд ашигласан баримт бичгүүд.

14.5. Харилцагчийн хөрөнгийг өөр кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдэд шилжүүлэхдээ хөрөнгө болон баримт бичгийг хүлээлцсэн тухай акт үйлдэх ба дараах мэдээллийг агуулсан байна:

14.5.1. хөрөнгө хүлээлцсэн акт үйлдсэн огноо;

14.5.2. харилцагч, түүнд шинээр үйлчлэх кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдтэй гэрээ байгуулсан огноо;

14.5.3. хөрөнгийг нь хүлээлцэж буй харилцагчийн талаарх мэдээлэл;

14.5.4. хөрөнгө хүлээлцсэн акт үйлдсэн өдрийн кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд дэх харилцагчийн дансан дахь бэлэн мөнгө, үнэт цаасны үлдэгдэл; .

14.5.5. шинээр кастодианы үйлчилгээ үзүүлэх этгээдэд шилжүүлэх бичиг баримтын жагсаалт

14.5.6. талуудын холбогдох мэдээлэл, гарын үсэг;

14.5.7. бусад шаардлагатай мэдээлэл.

14.6. Кастодианы үйлчилгээ үзүүлж байсан болон шинээр үзүүлэх этгээдийн тэмдэг, гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогчийн гарын үсгээр баталгаажсан харилцагчийн хөрөнгийг шилжүүлэх тухай актыг 4/дөрвөн/ хувь үйлдэх ба харилцагч, эсхүл түүний итгэмжлэгдсэн этгээд, кастодианы үйлчилгээг үзүүлж байсан этгээд болон шинээр үзүүлэх этгээд, төвлөрсөн тов хадгаламжийн байгууллага тус бүрд нэг нэг хувийг олгоно.

#### **Арван тав. Хяналт, шалгалт, хариуцлага**

15.1. Хороо кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх гэнэтийн болон хуваарьт хяналт, шалгалтыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хийж, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Хороо шаардлагатай гэж үзвэл энэхүү хяналт шалгалтын үр дүнг Монголбанкинд хүргүүлж болно. Харин кастодианы үйл ажиллагаа явуулж банкинд хийх газар дээрх хяналт, шалгалтыг Мошолбанк, Хороо хамтран гүйцэтгэнэ.

15.2. Хороо болон Монголбанкнаас кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдийн дор дурдсан болон шаардлагатай гэж үзсэн бусад үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалтыг хийнэ:

15.2.1. холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт;

15.2.2. дотоод дүрэм, журам, заавар, гэрээ, тэдгээрийн хэрэгжилт;

15.2.3. харилцагчтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүрэг, түүний хэрэгжилт;

15.2.4. кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа;

15.2.5. заавал байлгах хөрөнгийн доод хэмжээ болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлт;

15.2.6. харилцагчийн хөрөнгийн найдвартай байдлыг хангасан байдал;

15.2.7. сонирхлын зөрчил үүссэн бол түүнийг шийдвэрлэсэн байдал;

15.2.8. байгууллагын дотоод үйл ажиллагааны зохион байгуулалт;

15.2.9. мэдээллийг ашиглах, хадгалах, хамгаалах дотоод үйл явц;

15.2.10. мэдээ, тайлан, бичиг баримтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Хороо болон Монголбанкинд тайлагнах;

15.2.11. харилцагчид болон олон нийтэд мэдээлэл хүргэх үйл ажиллагаа;

15.2.12. Хороо болон Монголбанкнаас хамтран мэдээллийн технологийн орчин аюулгүй, найдвартай, бүрэн тоноглогдсон байдал;

15.2.13. Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад баримт.

15.3. Энэ журмын 15.1-д заасан эрх бүхий этгээдээс хийсэн шалгалтаар кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь энэ журам, холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн нь тогтоогдвол тухайн кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэл болно.

15.4. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь гэрээнд заасан үүргээ биелүүлдэггүйгээс бий болсон хохирлыг Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу барагдуулна.

15.5. Харилцагчийн өөрийн гаргасан хөрөнгө оруулалтын шийдвэрийн улмаас бий болсон аливаа хариуцлагыг кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд хүлээхгүй.

15.6. Хороо энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих ба илэрсэн зөрчилд хууль тогтоомжийн дагуу хариуцлагыг ногдуулна.

### **Арван зургаа. Хороо болон Монголбанкинд мэдээлэл хүргүүлэх**

16.1. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь өөрийн болон харилцагчийн нэрийн өмнөөс гүйцэтгэсэн үнэт цаасны гүйлгээний мэдээллийг Хороонд сар бүр хуанлийн сар дууссанаас хойц 2 /хоёр/ долоо хоногийн дотор мэдээлж байх үүрэгтэй.

16.2. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь мэдээллийг Хороонд цахим хэлбэрээр хүргэх бөгөөд уг мэдээлэл нь дараах шаардлагыг хангасан байна:

16.2.1. мэдээлсэн мэдээллийн хамгаалалт болон нууцлалыг баталгаажуулах;

16.2.2. гүйлгээний мэдээллийн алдааг засах болон тодорхойлох аргачлал болон механизмыг бий болгох;

16.2.3. гүйлгээний мэдээллийн эх үүсвэрийг баталгаажуулах аргачлал болон механизмыг бий болгох;

16.2.4. Хороо болон Монголбанкнаас тавьсан мэдээлэх маягтын шаардлагын дагуу мэдээллийг гаргаж огч чадах чадвартай байх.

16.3. Гүйлгээний мэдээлэл нь үнэт цаастай холбоотой дараах мэдээллийг агуулсан байх:

16.3.1. кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдийн гүйцэтгэсэн гүйлгээг Хорооноос баталсан дүрмийн дагуу тодорхойлсон;

16.3.2. өдөр болон цаг, хэзээ гүйлгээг гүйцэтгэсэн;

16.3.3. кастодиан банкны мэдээлсэн гүйлгээний /худалдсан худалдан авсан/ төрөл;

16.3.4. кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд нь өөрийн данс ашигласан, эсхүл харилцагчийг төлөөлж тэдний данс ашигласны аль нь болох;

16.3.5. гүйлгээнд ашигласан санхүүгийн хэрэслийн талаарх тодорхойлолт;

16.3.6. гүйлгээнд ашигласан санхүүгийн хэрэгслийн төрөл болон тодорхойлолт;

16.3.7. өрийн бичгийн дуусах хугацаа;

16.3.8. гүйлгээ хийгдсэн үнэт цаасны нэгж бүрийн зах зээлийн үнэ, хураамж болон төлөгдсөн хүүг хасах, өрийн бичгийн хувьд үнэ нь валют, эсхүл хувиар тодорхойлогдож болно;

16.3.9. үнийн дүнг илэрхийлсэн мөнгөн тэмдэгт, өрийн бичгийн үнэ нь хувиар илэрхийлэгдсэн бол тодорхой хувь;

16.3.10. хувьцааны тоо ширхэг, бондын хувьд гүйлгээний нэрлэсэн үнэ;

16.3.11. гүйлгээнд оролцсон харилцагч талуудын тодорхойлолт;

16.3.12. гүйлгээг гүйцэтгэсэн газрын тодорхойлолт;

16.3.13. гүйлгээ цуцалсан талаар мэдээлэл

#### **Арван долоо. Хариуцлага**

17.1. Энэ журмыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай, Банкны тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулиуд болон хууль тогтоомжийн бусад актад заасан хариуцлага ногдуулна.

17.2. Кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээний хэрэгжилтэд энэ журмаар хариуцлага ногдуулахгүй.

---oO---

Харилцагчтай байгуулсан кастодиан үйлчилгээ үзүүлэх гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж болох компанийн бусад үйл ажиллагаа

- **Шингээлт (Assimilation):** Хуучин гаргасан хувьцаан дээрээ шинээр хувьцаа нэмж гаргах ба эхэн үедээ шинэ гаргасан хувьцаа нь хуучин хувьцаатайгаа нэг түвшинд байхгүй ба шингээлт хийсний дараа шинээр гаргасан хувьцаа нь хуучин хувьцаатайгаа яг ижил эрхтэй болсон байна.

- **Худалдаж авах (Acquisition):** Компани нь өөрийн цар хүрээгээ тэлж өсч хөгжихийг зорьдог. Энэхүү өсөлт нь органик органик бусаар хийгдэж болно. Өөрийн зүй тогтлоороо өсч хөгжиж байгааг органик хөгжил, бусад компанийг худалдаж авах, нэгтгэх замаар өсч хөгжихийг органик бус хөгжил гэнэ.

- **Дампуурал (Bankruptcy):** Компанийн өр төлбөр нь түүний актив хөрөнгийн зах зээлийн шударга үнэлэмжээс хэтэрснээс үүсэх бизнесийн уналт.

- **Нэмэлт үнэт цаас (Bonus Issue):** Компани нэмэлт үнэт цаас гарган одоо байгаа хувьцаа эзэмшигчдэд үнэгүй олгох

- **Нэмэлт эрх (Bonus Rights):** Одоо байгаа хувьцаа эзэмшигчиддээ шинээр гарах хувьцааг хөнгөлттэй нөхцлөөр авах эрхийг олгох

- **Бэлэн мөнгөөрх ногдол ашиг (Cash Dividend):** Жилийн эцэст компаний гүйцэтгэлээс хамааран олсон орлогоос ногдох хувийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон мөнгө хуваарилах

- **Хувьцаа эзэмшигчдийг төлөөлж нэхэмжлэл гаргах (Class Action):** Хувьцаа эзэмшигчдийн томоохон бүлэг, эсхүл түүний төлөөлөл болсон албан байгууллага компаний эсрэг хувьцаа эзэмшигчдэд мөнгө нэхэмжилж шүүхэд иргэний хэрэг хянан шийдвэрлүүлэхээр хандах

- **Бүртгэлээс хасах (Delisting):** Компанийн хувьцааг хөрөнгийн биржийн бүртгэлээс хасах

- **Компаний хуваагдал (De-merger):** Компани 2 ба түүнээс дээш тооны компани болон хуваагдахыг хэлэх ба хуучин компаний хувьцааг бүртгэлээс хасч шинэ компаниудын хувьцааг тогтоосон харьцаагаар бүртгэж авна.

- **Ерөнхий мэдэгдэл (General Announcement):** Компаний зүгээс хувьцаа эзэмшигчдэд тодорхой үйл явдлыг мэдэгдэх зорилгоор ашиглах ба уг мэдэгдлийг хэд хэдэн хэлбэрээр хүргэж болно.

- **Анхдагч зах зээлд үнэт цаас нийтэд арилжаах (Initial Public Offering):** Хувийн компаниас анх удаа хувьцаа гаргах арилжаа.

- **Татан буугдах (Liquidation):** Мөнгө ба хөрөнгийг хуваарилах үйл явц ба өрийг нэн түрүүнд төлж барагдуулна.

- **Үнэт цаасаар солих/хөрвүүлэх үүрэг (Mandatory Exchange / Mandatory Conversion):** Үнэт цаасыг ижил төстэй үнэт цаасаар солих /ихэвчлэн давуу эрхтэй хувьцаа болон хөрвөх бондоор/

- **Нэгдэх (Merger):** Хоёр ба түүнээс дээш тооны компани нэгдэж аль нэг компанийхаа нэрийг авах.

- **Нэр өөрчлөх (Name Change):** Хувьцаа эзэмшигчдийн хурлаар нэр солих тухай саналыг гаргаж шийдвэрлэх энэ шийдвэр нь компаний хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд нөлөөлөхгүй байна.

- **Хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх (Par Value Change):** Хувьцааг хуваахтай төстэй бөгөөд хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх замаар хувьцааны тоо ширхэгт өөрчлөлт оруулна.

- **Зохион байгуулалтын тогтолцоо (Scheme of Arrangement):** Толгой компани өөрийн охин компаниа өөртөө нэгтгэн авч хувьцаа эзэмшигчдийг нь авч үлдэх
- **Сонголтот ногдол ашиг (Scrip Dividend)** (жич: Их Британи Улсад ихэвчлэн энэ нэрээр ашиглагддаг): Хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр эсхүл тогтоосон харьцаагаар шинэ үнэт цаас хүлээж авах сонголт олгоно. Өгөгдмөл сонголт нь голдуу мөнгө байдаг.
- **Тасалбар олгох (Scrip Issuc):** Хувьцаа эзэмшигчдэд үнэгүй нэмэлт хувьцаа /хувьцаа, эрх, баталгаа/ огохийг хэлэх ба хувьцааны нэрлэсэн үпэд өөрчлөлт орохгүй.
- **Туслаа компани болж салах (Spin-off):** Толгой компанид охин компаний хувьцааг үнэгүй тараах
- **Хувьцаагаар олгох ногдол ашиг (Stock Dividend):** Хувьцаа хэлбэрээр эзэмшигчдэд хуваарилдаг ногдол ашиг.
- **Хувьцааг хуваах (Stock Split):** Компанийн хувьцааны зах зээлийн үнийг бууруулж хувьцаа эзэмшигч бүрт ногдох хувьцааны тоог нэмэгдүүлдэг нийтлэг арга.
- **Хоронгийн буцаалт (Return of Capital):** Хувьцааны нэрлэсэн үнэ өөрчлөгдөхөд хөрөнгө оруулагчид толөгдөх мөнгөн дүл.
- **Хувьцааны нийлүүлэлт (эсрэг сплит) (Reverse Stock Split):** Тодорхой тооны хувьцааг нэг шинэ хувьцаагаар солих хэлбэрээр компанийн хувьцааны зах зээлийн үнийг өсгөдөг арга.
- **Хувьцаа бэлэн мөнгөний сонголт (Cash Stock Option):** Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгаа бэлэн мөнгөөр эсхүл нэмэгдэл шинэ хувьцаа хэлбэрээр авах сонголт
- **Нэгдэх, нийлэх (санал хураалттай) (Merger with Elections):** Хоёр ба түүнээс дээш тооны компани нэгдэж нэг шинэ компани болно. Үр дүнд нь тогтоосон харьцааны дагуу хуучин компаниудын хувьцааг шинэ компаний хувьцаагаар солино.
- **Компани болж салах (санал хураалттай) (Spin-off with elections):** Охин компани нь толгой компанийн хувь нийлүүлэгчдийн эзэмшилд хувь тэнцүүлсэн байдлаар хувьцаа гаргаж бие даасан компани болж салах хэсэгчилсэн худалдааны хэлбэр.
- **Хувьцаа эзэмшигчдийн ээлжит/ээлжит бус хурал - Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн санал (AGM/EGM – proxy voting):** Нээлттэйгээр худалдаалагдсан бүх компаниуд ээлжит (жил бүр) хурал хийдэг ба хурал дээр компанийн удирдлага хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрөл шаардлагатай шийдвэрүүдийг тагилцуулдаг. Зөвшөөрлийг "дэмжсэн", эсхүл "таггалзсан" гэсэн байдлаар санал хурааж олгох эсэхийг шийдвэрлэдэг. Хувьцаа эзэмшигчид хуралд өөрийн биеэр, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчдөөр дамжуулж оролцож болно
- **Буцааж худалдаж авах програм/Дахин худалдаж авах санал (Buy-back program/ Repurchase Offer):** Компаниас хувьцаа эзэмшигчдэд компаний мэдлийн хувьцааг дахин худалдаж авах, эсхүл бусад үнэт цаасыг хувьцаанд хөрвүүлж авахыг санал болгодог. Ингэснээр эргэлтэд байгаа хувьцааны тоо буурдаг.
- **Ногдол ашгийн дахин хөрөнгө оруулалтын төлөвлөгөө (Dividend Reinvestment Plan):** Хувьцаа эзэмшигчид нь ногдол ашгаасаа гүйлгээний зардалгүйгээр нэмэлт хувьцаа авах эрхийг олгосон төлөвлөгөө.
- **Голланд дуудлага худалдаа (Dutch Auction):** Голланд дуудлага худалдааны саналд тодорхой тооны хувьцаа эцсийн дүнд худалдаалагдах үнийн хэлбэлзэл нь заагдсан байдаг. Хувьцаа эзэмшигчдээр ямар үнээр зарах тухай заалт гаргуулдаг. Бүх заалтууд тоологдсоны дараа, хамгийн бага үнэ санал болгосон хувьцаа эзэмшигчийн хувьцаа тодорхойлогдсон тооноос хэтрэх хүртэл, эсхүл үнийн хэлбэлзэлийн дээд хязгаар хүртэл борлуулагддаг.
- **Сондгой багцын санал (Odd lot Tender):** 100 ширхэг хувьцааг нэг багц гэж үзвэл 50 ширхэг хувьцаа нь нэг багц болж чадахгүй байгаа учраас түүнийг сондгой багц гэж нэрлэн тодорхой өгсөн үлээр зарах санал

- **Үнэ хаялцах эрх (Rights Auction):** Одоо байгаа хувьцаа эзэмшигчдийн дунд шинээр гаргах үнэт цаасыг худалдаж авах эрхийг үнэ хаялцуулан, хэн их үнэ өгсөн хувьцаа эзэмшигчид шинээр гаргасан хувьцааг худалдах эрх
- **Эрх олгох (Rights Issue):** суурь үнэт цаасыг эзэмшдэг хувьцаа эзэмшигчдэд ижилхэн суурь үнэт цаас, эсхүл хөрвөх бондыг урьдчилан тогтоосон харьцаагаар бодсон тоо хэмжээгээр болон үнээр захиалах эрхийг олгох
- **Захиалгын санал (Subscription Offer):** Одоо байгаа хувьцаа эзэмшигчдэд шинэ хувьцаа, эсхүл хөрвөх бондыг санал болгох
- **Эзэмших (Takeover):** Нэг компани нөгөөгөө саналын эрхтэй хувьцааны дийлэнхийг авах замаар эзэмших
- **Тендер санал (Tender Offer):** Компанийн тодорхой тооны хувьцааг тодорхой үнээр худалдаж авах санал.
- **Үнэт цаасаар солих/хөрвүүлэх эрх (Voluntary Exchange / Optional Conversion):-** Хувьцааг өөр хувьцаагаар, эсхүл мөнгөөр солих санал
- **Хөрвөх бондын хөрвүүлэлт (Conversion of convertible bonds):** Хөрвөх бондыг суурь үнэт цаасаар солих
- **Хүүгийн төлбөр (Interest payment/Coupon Payment):** Бонд гаргагч гэрээний нөхцлийн дагуу төлөх хүү.
- **Хугацаанаас өмнө өрийг хаах (Early Redemption):** Бонд гаргагч сонгосон эзэмшлийн өрийг хүүг нэмэгдүүлсэн дүнгээр хугацаанаас нь өмнө барагдуулах
- **Хугацаанаас өмнө өрийг хаах (Lottery, or Drawing):** Бонд гаргагч сонгосон эзэмшлийн өрийг хугацаанаас нь өмнө барагдуулах
- **Өрийг хугацаанаас омно хэсэгчлэн хаах (Partial Redemption):** Бонд гаргагч бондын тодорхой хэсгийн нэрлэсэн үнэ дээр хүүг нэмэгдүүлсэн дүнг эргэн төлөх хугацаанаас өмнө төлөх
- **Эцсийн төлбөр (Final Redemption):** Бонд гаргагч бондын нэрлэсэн үнэ дээр хүүг нэмэгдүүлсэн дүнг эргэн төлөх



**КАСТОДИАНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, НЭГЖИЙН  
УДИРДЛАГА БОЛОН БУСАД БОЛОВСОН  
ХҮЧНИЙ ТОДОРХОЙЛОЛТ**

1. Зохицуулалттай этгээдийн гүйцэтгэх захирал, нэгжийн удирдлага, бусад боловсон хүчин нь дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ:

• Овог, нэр:

• Эрхлэх албан тушаал:

• Төрсөн он, сар, өдөр:

• Иргэний харьяалал:

• Гэрийн хаяг:

• Утасны дугаар:


• Регистрийн дугаар:

• Одоо эрхэлж байгаа ажил:

- Хугацаа:

- Хаяг:

• Боловсролын талаар */Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/*



Д/д	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар

• Ажлын туршлага

Д/д	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он, сар, адар	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан

• гүйцэтгэх удирдлага, боловсон хүчний товч танилцуулга (аль нэг хуулийн этгээдийг төлөөлдөг эсэх, түүний үйл ажиллагаа, байршил, үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдтэй харьцаж байсан түүх, харилцагч банкууд, өөр аль нэг хуулийн этгээдийн хувь нийлүүлэгч эсэх, бусдад өр, зээлтэй эсэх одоо хууль хяналтыг байгууллагад хэрэг үүсгэгдэн шалгагдаж байгаа эсэх зэргийг бичнэ):

2. Гүйцэтгэх удирдлага, боловсон хүчний холбогдох этгээдийн байдал:

Нэгдмэл сонирхолтой этгээд /холбогдох этгээд/ гэдгийг Компанийн тухай хуулийн 99 дугаар зүйл, Банкны тухай хуулийн 3.1.2- дахь заалтад тодорхойлсноор тус тус ойлгоно.

Д/д	Таны юу болох	Овог, нэр	Регистрийн дугаар	Эрхлэж буй албан тушаал

*Нэгдмэл сонирхолтой этгээд /холбогдох этгээд/-ийн товч танилцуулгад урьд өмнө эрхэлж байсан ажил, торлийн байдал, аль нэг хуулийн этгээдийг төлөөлдөг эсэх, түүний үйл ажиллагаа, байршил, бусдад өр, зээлтэй эсэх, одоо хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдэн шалгагдаж байгаа эсэх зэргийг бичнэ.*

*Гүйцэтгэх удирдлага боловсон хүчний талаарх хууль хяналт, татвар, банк болон бусад холбогдох хуулийн этгээд, байгууллага, иргэдээс гаргуулан авсан тодорхойлолт, лавлагаа зэргийг хавсаргаав.*

.....-ийг толоөлж .....

/албан тушаал/

/...../

/...../

/гарын үсэг/

/овог, нэр/